



**“ХАШААТЫН ЦАВ” ХҮРЭН НҮҮРСНИЙ ИЛ
УУРХАЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ЖИЛИЙН ТАЙЛАН**



ДОРНОД, БАЯНТҮМЭН СУМ

ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр:	“Хашаатын цав” хүрэн нүүрсний ордыг ил аргаар ашиглах төсөл
Байршил:	Дорнод аймаг, Баянтүмэн сум
Төсөл хэрэгжүүлэгч:	“Меланж” ХХК
Улсын бүртгэлийн дугаар:	9011256001
Регистрийн дугаар:	5412153
Хаяг:	Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө-8 , Алтай бьюдинг, 3 давхар, 302 тоот
Утас:	+976-11- 95100426, 80550426
Факс:	+976-11-
Цахим хаяг:	envr@khashaatcoal.mn :
Хариуцах хүн:	Байгаль орчны мэргэжилтэн . Утас: 95100426, 80550426
БОНЕҮ, шийдвэрийн төсөл:	2021 оны 08 сарын 16-ны 2021/Т-100 дугаар БОНЕҮ–ний дүгнэлтийг гаргасан.
БОННҮ нэмэлт хийсэн ААН-ийн нэр, батлуулсан огноо:	Тус төслийн БОННҮ-ний нэмэлт тодотголыг “ЭКОЛОГИЙН БҮТЭЭМЖ” ХХК хийж гүйцэтгэж байна. 2023 он

АГУУЛГА

1.	Төслийн товч танилцуулга	
1.1	Төслийн нэр	4
1.2	Төслийн зорилго	4
1.3	Төсөл хэрэгжүүлэгчийн талаар мэдээлэл	4
1.4	Төслийн талбайн байршил	4
1.5	Ажиллах хүчний тухай мэдээлэл	5
2.	Төсөл хэрэгжиж буй газрын байгаль орчны төлөв байдал	6-8
3.	Уурхайн үйл ажиллагааны тухай	9-14
3.1	2023 оны уулын ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл	9
3.2	Уурхайн барилга байгууламж, дэд бүтэц	10
3.3	Төсөлтэй холбогдох тусгай зөвшөөрөл, гэрчилгээ	14
3.4	Байгаль орчны үнэлгээний тайлангууд	14
3.5	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайлангийн бүтэц	14
4.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний товч тордорхойлолт	15-17
4.1.	Төслийн гол болон болзошгүй нөлөөллүүд, бууруулах арга хэмжээ	15-17
5.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	18-
5.1.	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийн бууруулах арга хэмжээний биелэлт	18-22
5.2.	Газрын гадарга, газрын хэвлийн үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	23-24
5.3.	Гадаргын болон газрын доорхи усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл	25-30
5.4.	Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	31-34
5.5.	Ургамлан нөмрөг, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	34-39
6.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	40-
6.1.	Эдвэрсэн газарт нөхөн сэргээлт гүйцэтгэсэн ажил	40-42
6.2.	Тэрбум мод хөтөлбөрийн хүрэн ногоон төгөл байгуулах ажил	40-42
7.	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	43
7.1.	Тарвага нутагшуулсан ажилд мониторинг хийсэн ажил	43-45
8.	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний биелэлт	46
9.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний биелэлт	46
10.	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	47-50
10.	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	51-59
11.	Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	60-65
12.	Багаь орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч талуудад тайлагнах ажлын биелэлт	66-68
13	Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	69
12.1.	Агаарын чанарын хяналт, шинжилгээ	70-75
12.2.	Уурхайн усны хяналт, шинжилгээ	76-80
12.3.	Хөрсний бохирдлын хяналт, шинжилгээ	81-84
14	Дүгнэлт	85-86
15	Хавсралт	87

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн нэр: “Хашаатын цав” нэртэй хүрэн нүүрсний орд ашиглах төсөл

1.2. Төслийн эрхэм зорилго:

Хашаатын цав нэртэй хүрэн нүүрсний ордыг байгаль орчинд аль болох сөрөг нөлөөлөл багатайгаар ашиглан Монгол улсын эрдэс баялгийг эдийн засгийн эргэлтэд оруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, улс, орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэхэд төслийн гол зорилго оршино.

1.3.Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын товч танилцуулга:

Төсөл хэрэгжүүлэгч нь 2010 онд геологи, уул уурхайн чиглэлээр зөвлөгөө өгөх, үйл ажиллагаа явуулах үндсэн чиглэлээр, мөн гадаад худалдаа, зуучлал, уул уурхайн тоног төхөөрөмжийн худалдаа, геофизикийн судалгаа зэрэг туслах чиглэлүүдтэйгээр байгуулагдсан.

2017 онд АМГТГазраас зарласан Дорнод аймгийн Баянтүмэн сумын нутагт орших Хашаатын цав нэртэй газар сонгон шалгаруулалтад оролцон шалгарч тус газар геологи хайгуулын иж бүрэн судалгааны ажлыг хийн гүйцэтгэн нүүрсний орд газрыг нээн илрүүлж ашиглалтад бэлдээд ажиллаж байна.


“Меланж” ХХК нь MV-020936 тоот ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшдэг ба уг тусгай зөвшөөрлийн талбайд 2017 онд өөрийн хөрөнгөөр хайгуул хийн нөөцийг ЭБМЗ-өөр батлуулсан. Тухайн ТЭЗҮ-ийн дагуу уурхайн ашиглалтыг 2021 оны 12 сараас эхлэн хөрс хуулалтын ажил эхүүлсэн байна.

1.4. Төслийн байршил:

MV-020936 тоот ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Хашаат цав”-ын хүрэн нүүрсний нүүрсний орд нь Дорнод аймгийн Баянтүмэн сумын нутагт К-47-35 дугаар планшитэд 3977.24 га талбайг хамран оршино. Төслийн талбай нь Чойбалсан хот ба Баянтүмэн сумаас зүүн урагш 70 км, Дорнод аймгийн Матад сумын төвөөс хойш 94 км, Улаанбаатар хотоос зүүн зүгт 742 км зайтай.

Хүснэгт 1. MV-020936 тоот тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүд

Д/д	Уртраг			Өргөрөг		
	Град	мин	сек	град	мин	сек
1	115	32	0	47	55	15.23
2	115	26	15	47	55	15.23
3	115	26	15	47	58	15.19
4	115	32	0	47	58	15.1



Зураг 1. Хашаатын цав хүрэн нүүрсний ил уурхайн байршил зураг

1.5. Ажиллах хүчний тухай мэдээлэл

“Хашаатын цав” уурхайн үйл ажиллагаа эхэлсэн хугацаанаас нийт 200 хүн ажилласан байна. Тухайн ажилчид инженер техникийн болон бусад ажилчдыг УБ болон орон нутгаас авч ажиллуулж байна. Ажилчид нь уурхайд 14 хоног ажиллах 14 хоног амрах хуваарьтай байна. Төслийн талбайд 11 сарын байдлаар 200 гаруй нийт ажилчид байна. Төслийн талбайд кемпийн үйлчилгээ, кетиринигийн “Ган Алтан Наран” ХХК нь 30 ажилчидтай, уулын ажил гүйцэтгэх “Зак Майнинг” ХХК нь 140 ажилчидтай, “Меланж” ХХК болон харуул хамгаалалтын компани нийлж 30-н ажилтантай байна.

ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

Физик газарзүй

Монгол орны нутаг дэвсгэрийн гадарга нь Сибирийн өмнөд уулсаас Төв Азийн тал газарт шилжих шилжилтийн мужид, умарт зүгийн хүйтэн чийглэг уур амьсгалаас өмнө зүгийн хэт хуурай уур амьсгалд шилжих алгуур шилжилтийн нөхцөлд бүрэлдэн тогтсон байна.

Уул зүй

“Хашаатын цав” хайгуулын талбай нь Дорнод талын их мужийн Мэнэнгийн талархаг дэд мужид хамаарах ба далайн түвшнээс дээш 570-800м-ийн өндөрт оршино. Газрын гадаргын байдал нь нам гүвээт талархаг, хэдэн арван метр харьцангуй өндөртэй ухаа гүвээт тал зонхилох ба тэдгээрийн хооронд жижиг хотос болон тэгш гадарга оршдог. Талбайн өмнө талд Нүүрст-Уул (727.6м), Хашаатын цав (792.7м) зэрэг өндөрлөгүүд, Баян-Усны хонхор, Их, Бага халуун шаварт нуурын хөндий (572.9м), Ар хашаатын цайдам зэрэг хотгорууд ялгагдана. 100 орчим метрийн харьцангуй өндөршилтэй толгодлог гадаргуу нь нэгээс хоёрдугаар эрэмбийн усан хагалбаруудыг үүсгэдгээс Хашаат цавын нэгдүгээр эрэмбийн усан хагалбар нь Хэрлэнгийн ай сав, Халх гол-Нөмрөгийн ай савыг заагладаг Дорнод Монголын гол усан хагалбар юм.

Цаг уур

Талбай нь нилээд өргөгдсөн тэгш өндөрлөгт хамаарах бөгөөд дэлхийн уур амьсгалын бүсчлэлээр хойд сэрүүн бүсэд харьяалагдан, далай тэнгисийн зүгээс ирэх чийглэг дулаан уур амьсгал Хянганы уулсаар хаагдсаны улмаас эх газрын эрс тэс уур амьсгалтай, жилд унах хур тунадасын хэмжээ бага байдаг. Судалгааны талбайн (ер нь Дорнод Монголын) цаг уурын төлөв байдал нь нэгэнт эх газрын эрс тэс шинжтэй тул өвлийн улирал нь урт хүйтэн, зун нь богино дулаан, харин хавар намрын улирал нь богиновтор хэр нь хүйтний солилцоо их байдаг. Хамгийн дулаан байх үе нь 7-р сард, хүйтэн нь 1-2-р сард тохиолдоно. Жилийн дундаж температур 0оС+2оС ба хамгийн хүйтэн байх хоёрдугаар сарын дундаж температур +20°С байдаг. Баруун хойноос болон зүүн хойноос чиглэлийн салхи зонхилох ба Төв Азийн Сибирийн максимаас үүсэлтэй антициклон голлох үүрэгтэй. Зуны эхнээс өндөр даралттай муссон салхины үе эхэлдэг.

Орон нутгийн чанартай говийн салхи зуны төгсгөлд онцлогтой. Салхины хурд 30-50 км/цаг хүрэх нь бий. Өвөл 11-р сард эхэлж, 3-р сарын сүүлчээр хаврын урь орох, 6-р сард зуны улирал эхлэн 8-р сарын сүүлчээс намрын уур амьсгал ордог. Жилийн туршид салхитай өдрүүд зонхилдгоос хөрсний чийгшил маш муу, хуурайшилт ихтэй. Жилийн ихэнх өдрүүд нь цэлмэг нартай байдаг бөгөөд өвөл цас их унасан үед агаарын чийгшил 70-80% хүрэх ба зуны хамгийн чийглэг хур борооны үе 8-р сард ч агаарын чийглэг 40%-иас хэтрэхгүй.

Хур тунадасны дундаж уналт 180-210мм орчим бөгөөд, хамгийн их унах үе нь 7 сард 250 мм хүрдэг. Олон жилийн ажиглалтаас 10-р сарын 20-оос 11-р сарын 5-ны хооронд цасан бүрхүүл тогтож, энэ нь гуравдугаар сарыг дуустал үргэлжилнэ. Цасан бүрхүүлийн зузаан олон жилийн дунджаар 4-5 см зарим зудтай жил 25 см хүрэх нь бий. Агаарын даралт улирал бүрд харилцан адилгүй, жилийн дундаж даралт 1022-1034м/б, харин хаврын улиралд агаарын даралт тогтворгүй 20-12 м/б-аар багасах бөгөөд энэ нь салхи ихтэй чиглэл нь тогтворгүй болох нөхцлийг бүрдүүлнэ.

Усан сүлжээ

Нуурын болон гадаргуугийн усны тархалтын хувьд маш дутмаг. Төв азийн гадагш болон тогтмол урсгалгүй гол мөрний дүүрэгт (Мэнэнгийн ай сав) хамаарна. Төслийн талбайн хэмжээнд гол горхи байхгүй, хур тунадсаар тэжээгддэг давстай нуур тойрмууд байх ба хур бороо багатай жилүүдэд ширгэдэг. Хашаат цайдам, Баян-усны, Их халуун шавар, Бага халуун шаварт зэрэг нуурууд бий. Мөн эрдэжилт ихтэй гар худгууд байдаг. Нутгийн иргэд, малчид гар болон гүний худгуудын усаар малаа усалж, ахуйн болон ундны хэрэгцээгээ хангадаг.

Хөрс, ургамал

Тал хээрийн бүсийн хүрэн, цайвар хүрэн хөрс зонхилно. Мөн Их бага халуун шаварт нуурын хөндий, Баян-Усны говь, Уртцагааны говь зэрэг газраар давсархаг сайрын хөрстэй. Энд хазаар өвс, бутуул, ерхөг согоовор, хиаг, таана, агь, шивээт хялгана зэрэг шим тэжээл сайтай өвс ургамал зонхилох тул бэлчээрийн чанарын хувьд илүү сайн. Энэ төрлийн хөрсөнд ургамалжилт нягт, өндөр ургасан байдаг тул хадлан бэлтгэхэд тохиромжтой. Баян-усны говь, Их бага халуун шаварт нуурын хөндий, Урт цагааны говь зэргээр бударгана, таана, харгана, хазаар өвс зонхилон ургана. Зуны улиралд аянга цахилгааны улмаас тал хээрийн түймэр гарах тохиолдол цөөнгүй бөгөөд хавар намрын хуурайшилттай үед тал хээрийн түймэр гарах эрсдэл их байдаг.

Амьтны аймаг

Орон нутгийн газарзүйн онцлог цаг уурын нөхцөл зэргийг харгалзан, Монгол Дагуурын ба Хойд говийн тойрогт хамааруулан үзэж болох юм. Монгол Дагуурын тойрогт гол төлөв үлийн цагаан огтоно, хэргэлзээт огтоно, үхэр огдой, зурам, шар сүүлт, чичүүл зэрэг мэрэгчид туурайтнаас цагаан зээр, араатнаас үен, өмхий хүрэн, хярс, үнэг, мануул, илбэнх, дорго, чоно амьдардаг. Хойд говийн тойрогт үхэр огдой, сүүлт чичүүл, улаан шанаат зурам, алаг даага, туурайтнаас цагаан зээр, араатнаас өмхий хүрэн, хярс, чоно голлон амьдарна. Жигүүртнээс тас, элээ, сар, хэрээ зэрэг махчин шувууд байхаас гадна янз бүрийн жижиг шувууд болон болжмор элбэг байдаг.

Эдийн засаг, хүн ам

Баянтүмэн сум нь дэд бүтэц сайн хөгжсөн аймгийн төв Чойбалсан хотын ойролцоо 12 км зайд байрладагаараа онцлог бөгөөд засаг захиргааны анхан шатны нэгж 4 багтай, 2085 хүн амтай, 82942 толгой малтай, төсвийн 5, хувийн хэвшлийн 11 байгуулага, 2 хоршоо, малчдын 23 бүлэг, 103 хүүхэд 26 багш ажиллагсадтай ерөнхий боловсролын сургуультай, соёлын төв, шуудан холбоо тус тус үйл ажиллагаагаа явуулж байна. Тус сум нь 832080.0 га газар нутагтайгаас газар тариалан 7203.7 га, хөдөө аж ахуйн 739143.4га талбайг хамрана. Хөдөлмөрийн насны 1210 иргэнээс төрийн байгууллагад 165, хувиараа хөдөлмөр эрхлэгч 368 иргэн байна.

Дэд бүтэц

Сүүлийн жилүүдэд сумуудад улс, орон нутгийн хөрөнгө оруулалт төсөл хөтөлбөрийн хүрээнд бүтээн байгуулалтын ажлууд хийгдэн 24 цагийн эрчим хүч, интернэт, үүрэн телефоны сүлжээ нэвтэрсэн байна. Сумын хүн амын ихэнх нь халхууд болон цөөн тооны буриад, барга ястнууд амьдардаг. Хашаатын цав талбай нь сумын төвөөс зайтай, хилийн хоройтой бүсэд байрладаг учир хүн амын нягтрал маш сийрэг, Халх гол болон Сүмбэрийн төв замаас 10-15 км зайд байрлана.

Зам харилцаа

Улаанбаатар хотоос замын ихэнх хэсгийг хар замаар, болон нэвтрэлт сайтай шороон замаар явж хүрнэ. Харин Матад сумын төв хүртэл шулуун зам байхгүй. Сүмбэр

сумын замаар хазайж 137 км явж хүрнэ. Матад сумын төвөөс Чойбалсан хот хүртэл 150 км орон нутгийн чанартай шороон замтай болно. Өндөр ургасан шивээ, өвс ургамлаар хучигдсан дош, довуудтай. Хуурайшилттай үед өндөр ургасан шивээн толгой, өвс ургамал нь автомашины мотор, яндаг зэрэгт хуримтлагдан улмаар шатах, хээрийн түймэр гарах тохиолдол цөөнгүй гардаг.

ГУРАВ. УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

3.1. Уулын ажлын гүйцэтгэл:

“Хашаатын Цав” хүрэн нүүрсний ил уурхайн төслийн уул ашиглалтын байдал 2023 оны 11 сарын байдлаар уурхайн уулын цул 5,023,463 м³, хөрс хуулалт 4,642,637 м³, шимт хөрс 20,772 м³, 371,456 м³ нүүрс олборлосон байна.

Хүснэгт 2. Уурхайн үйл ажиллагаанд өртсөн талбайнууд

№	Хэмжээсүүд	Талбай, га	2023 онд
1.	Уурхайн олборлолтын талбай	80.0	5,023, 463 м ³
2.	Хөрсний овоолго	149	4,642,637 м ³
3.	Зам талбай	29.6	-
4.	Шимт хөрс	29.0	20,772 м ³
5.	Засварын талбай	30.0	-
6.	Нүүрсний агуулах	19.0	371,456 м ³
7.	Пүүний талбай	13.0	хуучин талбай
8.	Пүүний зам	8.0	шинээр нэмсэн
9.	Ус зайлуулах усан сангийн талбай	0.6	шинээр нэмсэн

Хүснэгт 3. Уурхайн уулын цул, нүүрс олборлолтын гүйцэтгэл

Он/сар Уурхайгаас нийт гарсан уулын цулын задаргаа

		Хөрс (м3)	Шимт хөрс (м3)	Нүүрс		Нийт
				(м3)	тонн	
2023	1-р сар	16,466	-	2,496	14,370	28,962
	2-р сар	193,796	-	7,040	42,596	230,836
	3-р сар	704,608	-	12,791	14,709	717,399
	4-р сар	552,448	10,407	45,364	52,169	608,219
	5-р сар	714,870	-	128,870	148,201	843,740
	6-р сар	830,191	-	14,059	16,168	844,250
	7-р сар	598,624	-	-	-	598,624
	8-р сар	422,500	-	11,897	13,682	434,397
	9-р сар	289,109	10,365	33,953	39,046	333,427
	10-р сар	206,807	-	26,535	30,515	233,342
	11-р сар	-	-	-	-	-
	12-р сар	-	-	-	-	-
	Нийт	4,529,419	20,772	323,005	371,456	4,873,196


Уурхайн ажиллах горим:

Уурхайн үйл ажиллагаа нь тасралтгүй ажиллагаатай явагдах бөгөөд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу олон нийтээр амрах баяр ёслолын хоногууд, цаг агаарын хүндрэл, засвар үйлчилгээ зэрэг хүчин зүйлүүдээс шалтгаалж болно. Хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна. Уурхайн 14 хоног ажиллаж, 14 хоног амрах үндсэн ээлжтэй байна.

3.2. Уурхайн барилга байгууламж, дэд бүтэц

Ил уурхай:

“Хашаатын цав” хүрэн нүүрсний ил уурхайн олборлолтын талбай 80.0 га талбайн тэлэлт хийгдээгүй 2023 онд уурхайн уулын цул 5,023,463 м³, хөрс хуулалт 4,642,637 м³, шимт хөрс 20,772 м³, 371,456 м³ нүүрс олборлосон байна.



Зураг 2. Ил уурхайн харагдах байдал

Уурхайн дотоод болон гадаргуугийн зам

Автозамын техникийн нөхцөл нь замын норм дүрмийн дагуу хоёр урсгалтай, замын зорчих өргөн тооцоогоор 18.5м, сонгосон өргөн нь 20м, замын дагуугийн хамгийн их налуу 120% байна. Хашаатын цав ордын цаашдын ашиглалтын хэтийн төлөв, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, ахуйн эрүүл таатай орчинг бий болгох зорилгоор үйлдвэрлэлийн, бусад замуудын тоосжилтыг дарж, замын арчилгааг байнгын хийж байна.



Зураг 3. Ил уурхай дотоод зам

“Хашаат цав”-ын хүрэн нүүрсний ордын дэд бүтэц болох уурхайн цахилгаан хангамж, ус хангамж, дулаан хангамж, хотхоны барилга болон зам, харилцаа холбооны барилга байгууламжтай байна.

Засварын газар:

Засварын газрыг ил уурхайн баруун хойд талд 1100 м зайд байрлана. Засварын талбай нь тоног төхөөрөмж эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд хурдан шуурхай засварын газарт хүргэхэд ойр байх давуу талтай. Засварын газрыг аюулгүй ажиллагааны дүрэм стандартын дагуу барьж тоноглоно. Засварын газрын талбай нь 1500м² бөгөөд ажлын

байр, сэлбэг ба шатах тослох материалын агуулах, засвар үйлчилгээний граш, тоног төхөөрөмжийн зогсоолын талбай зэргээс бүрдэнэ.



Зураг 4. Ил уурхайн засварын газар

Замын ашиглалт, үйлчилгээ

Ил уурхайн дотоод тээврийн автозамыг байнга хянах ба засч тэгшлэх, тоос дарах зэрэг ажлууд хийгдэнэ. Зам засвар, ашиглалт, үйлчилгээний ажилд зам тэгшлэх, замын бартаа саадыг арилгах, замын эвдрэлийг засах, хальтиргаа гулгаа үүсэхээс хамгаалж зам дээр шороо цацах, замыг бороо болон шар усны үерээс хамгаалах зэрэг ажлууд орно. Замын засвар үйлчилгээ, ул талбайн цэвэрлэгээний ажлыг үйл ажиллагааны явцад байнга хийж гүйцэтгэнэ. Үүнд Shantui SD-16 бульдозер, LIUGONG CLG835 утгуурт ачигч, LIUGONG CLG414 автогрейдер ашиглах ба шаардлагатай тохиолдолд уурхайгаас нэмэлт тоног төхөөрөмж татан ажиллуулна.

Цахилгаан хангамж

Ил уурхай, засварын хэсэг болон бусад ашиглалтын туршид цахилгаан эрчим хүч хэрэглэх цахилгаан хэрэглэгчдийн цахилгаан ачаалал, тэдгээрийн цахилгаан эрчим хүчний зарцуулна. Уурхайн ашиглалтын үед цахилгааны үндсэн гурван хэрэглэгч байна. Үүнд:

1. Аж ахуйн хэсэг
2. Уурхайн хэсэг
3. Засварын хэсэг

ДҮЕГ500DSHS маркийн цахилгаан генераторыг Япон улсаас албан ёсны эрхтэйгээр “Юнитра” ХХК борлуулдаг бөгөөд 36.1 кВт-ын цахилгааны хэрэглээг хангах хүчин чадалтай юм. Уурхайн гэрэлтүүлэг, ажилчдын найдвартай ажиллагааг хангах үүднээс хөрөнгө оруулалт хэсэгт 2 ширхэг ба уурхайн ахуйн хэрэгцээнд 1 ширхэг генератор ашиглаж байна.



Зураг 5. Уурхайн кемпийн цахилгааны үүсгүүр /цахилгаан генератор/
Уурхайн хотхон

Хашаатын цав уурхайд 2023 онд оператор туслан гүйцэтгэгч компани нэг, кемп кетерингийн үйлчилгээний нэг компани ажилчдын хотхонд нийт 250 орчим хүн ажиллаж амьдарч байна. Уурхайн ашиглалтын хугацаанд уурхайн оффис, ажилчдын байр, цайны газар, халуун усны газар, засварын газар, харуулын байр зэргийг урт хугацаанд ашиглагдах сэндвичэн хийцийн барилга байгууламжтай.



Зураг 6. Уурхайн ажилчдын хотхон

Уурхайн усан хангамж, усны хэрэглээ:

Уурхайн унд-ахуйн уурхайн кемп дээр гаргасан 2 гүний худгаас, зам талбайн усалгааны усны хэрэглээг уурхайн уурхайн шүүрлийн уснаас ханган ажиллаж байна.

“Ган алтан наран катеринг” ХХК-ний уурхайн кемпийн ундны усны гүний худгийн ундарга 2.0 л/сек, худгийн өрөмдлөгийн гүн 73 метр, уст давхарга нь 49-51 метр байна. Мөн компани ногоон байгууламжийн усалгааны зориулалтаар ашиглаж буй гүний худгийн ундарга 2.0 л/сек, худгийн өрөмдлөгийн гүн 120 метр, уст давхарга нь 97 метр, дундаж зузаан нь 90 метр байна.



Зураг 7. Хашаатын цав уурхайн шүүрлийн ус, ногоон байгууламжийн усалгааны болон унд-ахуйн зориулалтаар ашигладаг гүний худгуудыг тоолууржуулсан байдал

3.2. Төсөлтэй холбогдох тусгай зөвшөөрөл, гэрчилгээ

Хүснэгт 4. Ашигт малтмалын ашиглалтын эзэмшдэг тусгай зөвшөөрлүүд

№	Тусгай зөвшөөрлийн төрөл	Дугаар	Хүчинтэй хугацаа
1	Хашаат цав	MV-020936	2047.09.29

Хүснэгт 5. Хашаатын цав уурхайн газар ашиглах зөвшөөрөл авахаар өгсөн газрын жагсаалт

№	Газар эзэмших зориулалт	Гэрчилгээний дугаар	Газрын хэмжээ /га/	Хүчинтэй хугацаа
1	Технологийн зам	-	96.5 км	-
2	Хогийн цэг	-	0.25	-
3	Нүүрс тээврийн зам	-	8.0	-
4	Хөрсний овоолго	-	218.5	-
5	Ил уурхай	-	120.5	-
6	Гаалийн хяналтын бүс	-	8.3	-
7	Засварын газар	-	4.0	-
8	Шимт хөрсний овоолго	-	47.5	-
9	ШТС	-	1.0	-
10	Уурхайн хотхон	-	36.61	-
11	Нүүрс буулгах талбай	-	8.46	-
12	Юнител	-	0.7	-
13	Усан сан	-	7.6	-
14	Түр засварын талбай	-	10.6	-

“Меланж”ХХК нь Хашаатын цавын хүрэн нүүрсний ил уурхайн Байгаль орчинд нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг (БОННУ) 2021.10.21-нд “Экотайкүүн”ХХК мэргэжлийн байгууллага гүйцэтгэсэн. Одоогийн байдлаар уурхайн ТЭЗҮ-д 2022онд орсон нэмэлт тодотголтой холбоотой БОННУ-ний нэмэлт тодотгол хийгдэж байна.

Хүснэгт 6. Хүчин төгөлдөр уурхайн БОННУ-тайлангууд

№	БОННУ-ний тайлангийн нэр	Батлагдсан он
1.	Дорнод аймаг Баянтүмэн суманд хэрэгжих “Хашаат цав нэртэй хүрэн нүүрсний ордыг ил аргаар ашиглах” төслийн БОННУ	2021.11.сар
2.	Дорнод аймаг Баянтүмэн суманд хэрэгжих “Хашаат цав нэртэй хүрэн нүүрсний ордыг ил аргаар ашиглах” төслийн БОННУ	хийгдэж байна
3.	2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө	2023.04.24

3.3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн бүтэц

Хашаатын цав уурхайн МҮ-020936 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд явагдаж байгаа үндсэн олборлолтын үйл ажиллагаанаас тэдгээрийн БОННУ-үүдийг холбогдох хууль, журмын дагуу БОАЖЯам баталсан болно.

Хашаатын цав нүүрсний уурхайн 2023 оны Байгаль орчны Менежментийн Төлөвлөгөөний Биелэлтийн Тайлан нь үндсэн олборлох үйл ажиллагааны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг нэгтгэсэн болно.

ДӨРӨВ. ТӨСЛИЙН ГОЛ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТОВЧ

4.1. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, бууруулах арга хэмжээ УУР АМЬСГАЛ

<p>Төслийн үйл ажиллагаанаас уур амьсгалд үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Хур тунадастай өдрийн тоо нэмэгдсэнээр олборлолтын үйл явц саатах ✓ Аадар болон аянга цахилгаантай өдрийн тоо нэмэгдсэнээр техник тоног төхөөрөмжийн үйл ажиллагаа зогсолтод хүрэх ✓ Үер урсцын нөлөөгөөр төслийн талбайд их хэмжээгээр ус орсноор уурхайлалт түр зогсох 	<p>Болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга, хэмжээний зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Төслийн талбайд техникийн болон хөдөлгөөний аюулгүй байдлыг маш сайн хангаж ажиллах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хорих шаардлагатай ✓ Техник хэрэгслийг талбайд гаргаж ажиллуулахгүй байх ✓ Зам, талбайг техник хэрэгсэлд тохиромжтой байдлаар засаж бэлдэх
--	---

АГААРЫН ЧАНАР

<p>Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах техник тоног, төхөөрөмжийг тээвэрлэх, суурилах явцад тоосжилт ихээр үүсэх; ✓ Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс тоосжилт үүсэх; 	<p>Болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга, хэмжээний зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс тоосжилт үүсэхээс сэргийлж зам талбайн усалгааг сайтар хийх;
---	--

УСАН ОРЧИН

<p>Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Төслийн үйл ажиллагаанд ашиглах усны хэмжээгээр газрын доорх усны нөөц багасах; ✓ Ахуйн бохир усыг ил задгай хаяснаар хөрсний ус бохирдох; ✓ Ариун цэврийн байгууламж, хог хаягдлын цэгийг стандартын дагуу байгуулаагүйн улмаас хөрсөнд нэвчилт үүсэх, ул хөрсний усыг бохирдуулах; 	<p>Болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга, хэмжээний зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Төслийн үйл ажиллагаанд ашиглах боломжит усны нөөцөөс хэтрүүлэхгүй байх; ✓ Ахуйн шингэн хаягдлыг ил задгай асгахгүй байх, зориулалтын цэгт хаяж байх; ✓ Ариун цэврийн байгууламж, хог хаягдлын цэгийг стандартын дагуу хийж гүйцэтгэх;
---	---

ГАЗРЫН ГАДАРГА БОЛОН ХӨРСӨН БҮРХЭВЧ

<p>Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Хатуу хучилттай зам барих хүртэл газрын гадарга эвдрэлд өртөх болон хөрсөн бүрхэвч доройтох; 	<p>Болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга, хэмжээний зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Төслийн барилга байгууламж баригдаж эхлэхээс өмнө сайжруулсан шороон замыг ашиглалтад оруулах,
--	---

<ul style="list-style-type: none"> ✓ Барилга байгууламжийн нөлөөгөөр газрын хэвлий болон хөрсөн бүрхэвч чанараа алдах; ✓ Төслийн дотоод зам, талбай болон гадна талбайд олон салаа зам гаргахгүй байх; ✓ Уурхайлалтаар хөрсний морфологи болон физик шинж чанар алдагдаж хөрсний үржил шим буурах, ойр орчмын талбайн хөрс доройтолд өртөх; ✓ Эрүүл талбайн өнгөн хөрс овоолгод дарагдах, хөрсний гадарга дээр нарийн ширхэгт тоосны хучаас үе үүсэх; ✓ Хөрсний элэгдэл эвдрэл үүсгэснээр байгалийн ус салхины эвдрэлийг эрчимжүүлж хөрс салхинд хийсэх болон гадаргын урсцаар угаагдаж элэгдэх; ✓ Хүнд даацын машин механизм, түүний тээвэрлэлт, засвар үйлчилгээний улмаас шатах, тослох материал, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж хөрс бохирдуулах; 	<p>төслийн үйл ажиллагаа эхлэхэд хатуу хучилттай автозамыг ашиглалтад оруулах;</p> <ul style="list-style-type: none"> ✓ Төслийн талбайд маршрут гарган бусад хэсгээр тээврийн хэрэгслийг зорчуулахгүй байх; ✓ Тээврийн хэрэгслийн зогсоол, ногоон байгууламжийг зөв оновчтой төлөвлөх; ✓ Үржил шимт хөрсний овоолгыг стандартын дагуу тогтмол усалж, шинж чанарыг хамгаалж, тордож байх
--	--

УРГАМЛЫН НӨМРӨГ

<p>Төслийн үйл ажиллагаанаас ургамлын нөмрөгт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Төслийн барилга байгууламж, уурхайлалтын хэмжээгээр ургамлын нөмрөг бүрэн устах; ✓ Төслийн талбайд автотээврийн хэрэгсэл, хүний үйл ажиллагааны улмаас ургамал ургаж буй хэсгийг талхагдалд оруулах шиглагдаж буй тээврийн хэрэгслүүдээс нефтийн бүтээгдэхүүн алдагдаж, ургамлын нөмрөгийг гэмтээх, бохирдуулах; 	<p>Болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга, хэмжээний зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Төслийн талбайд ногоон байгууламжийг оновчтой төлөвлөх; } Хог хаягдлыг тогтсон нэг цэгт байршуулах; ✓ Түлш, шатах тослох материалыг ашиглаж буй орчинд тэдгээрийг нэвтэрч шүүрүүлэхгүй байх арга хэмжээг авч ажиллах ✓ Машин механизм, тээврийн хэрэгслийн нэгдсэн зогсоол, засвар үйлчилгээний зориулалтын талбай гарган орчны ургамлын талхлагдахаас сэргийлэх;
---	--

АМЬТНЫ АЙМАГ

<p>Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Дуу чимээний нөлөөгөөр ан амьтад дайжих, амьдрах орчин нь өөрчлөгдөх; ✓ Тоосжилтоос мал, амьтанд сөргөөр нөлөөлөх; ✓ Олборлолт хийсэн нүхийг хашаалахгүйн улмаас мал, амьтан унах ✓ Цагаан зээр, хар сүүлтийн амьдрах орчинд нөлөөлөх 	<p>Болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга, хэмжээний зөвлөмж: \</p> <ul style="list-style-type: none"> ✓ Төслийн лицензийн талбайн хязгаарыг хэтрүүлэхгүй байх; ✓ Үйл ажиллагааны явцад улирлаар нүүдэллэн ирдэг амьтдын байрших гол газар, коридор нутагт тэдгээр амьтдыг хамгаалах, тоо толгойг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх талаар орон нутгийн болон холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах, туслалцаа үзүүлэх; ✓ Амьтны аймгийг хамгаалахын тулд судалгаа шинжилгээ, сургалт сурталчилгаа, хяналт шалгалтын олон талт арга хэмжээг орон нутгийн холбогдох байгууллагууд, иргэдтэй хамтран цогцоор хэрэгжүүлэх; ✓ Хууль бус ан хийгчдийн үйл ажиллагааг таслан зогсоох, хууль бусаар ан агнуур хийхгүй байх талаар ажиллагсад болон нутгийн иргэдэд тогтмол сургалт сурталчилгаа хийж байх;
---	--

НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ

<p>Төслийн үйл ажиллагаанаас нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг нөлөөлөл:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Шинээр ажлын байр бий болох; ✓ Улс, орон нутгийн төсвийн орлого нэмэгдэх; ✓ Татварын орлого өсөх;

ТАВ. ТӨСЛӨӨС БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

5.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт
 “Хашаатын Цав” төслийн үйл ажиллагааны явцад буюу хөрс хуулалт, нүүрс олборлох тээвэрлэх үйл ажиллагаа болон уурхайн хаягдлын овоолгуудаас их хэмжээний тоос, тооцонцор үүсэх боломжтой бөгөөд энэ нь агаар бохирдуулагч гол хүчин зүйл болдог. 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд дараах 5 үндсэн чиглэлийн хүрээнд үйл ажиллагаагаа төлөвлөж тухайн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 7. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний гүйцэтгэл

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Биелэлт, тайлбар
<p>Хашаатын цавын хүрэн нүүрсний уурхайг ил аргаар ашиглах явцад уурхайгаас жилд дунджаар 2861.8 тн тоосжилт үүсэхээр байна.</p>	<ul style="list-style-type: none"> • Тоосжилт үүсэх уурхайн зам, олборлолтын бүс, талбайнуудад усалгаа тогтмол гүйцэтгэж үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах усанд уурхайн шүүрлийн усыг ашиглах, тухайн ашигласан усны төлбөрийг төлөх • Тоосжилт үүсэхээс сэргийлж хурдны хязгаарлалтыг мөрдөн ажиллах, хүчтэй салхи шуургатай үед уурхайн ажиллагааг түр зогсоох, уурхайн тоосжилтыг тогтмол хэмжих • Хашаатын цавын уурхайн талбайд тоосны тархалтын 2023 оны загварчлал хийх 	<p>Хашаатын цавын хүрэн нүүрсний уурхайг ил аргаар ашиглах явцад уурхайн тоосжилт их бага хэмжээгээр үүсэж байгаа тул уурхайн усалгааны ажлыг уурхай эхэлснээс хойш 3 сараас эхлэн 11 сар хүртэл тасралтгүй хийж гүйцэтгэсэн байна. Уурхайн тоосжилтод уурхайн олборлолтын гүний шүүрлийн усыг ашиглаж байна. Уурхайн зам талбайн усалгаанд 2 усалгааны машин тогтмол ажиллаж байна.</p>
<p>Уурхайн шороон болон сайжруулсан дотоод замуудаас тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр тоосжилт үүсэж агаарыг бохирдуулах</p>	<ul style="list-style-type: none"> • Уурхайн дотоод зорчих хэсгийн шороон замын хучилтыг сайжруулах, үйл ажиллагааны туршид арчлах, усалгаа хийх • Агаарын тоосжилтын шинжилгээний давтамжийг нэмэх, тогтмол хэмжилт хийх үр дүнд үндэслэсэн арга хэмжээг цаашид хэрэгжүүлэх 	<p>Уурхайн дотоод зам талбайнуудад, тээврийн шаардлагатай засвар үйлчилгээ, замын шаардлагатай газруудад нэмэлт хөрсний давхарлах дэвсэх арга хэмжээ авч ажилладаг байна.</p> <p>Уурхайн агаарын шинжилгээний хяналтын 8 цэгт агаарын тоосжилтын гэрээт эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн хяналт болон гүйцэтгэгч компаниуд сар бүр тоосжилтын түвшин ямар байгааг тогтмол хянаж ажиллаж байна.</p>

1. Тоосжилт үүсэх уурхайн зам, олборлолтын бүс, талбайнуудад усалгаа тогтмол гүйцэтгэж үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах усанд уурхайн шүүрлийн усыг ашиглах, тухайн ашигласан усны төлбөр төлөх

Уурхайн тоосжилт их бага хэмжээгээр үүсэж байгаа тул уурхайн усалгааны ажлыг уурхай эхэлснээс хойш 3 сараас эхлэн 11 сар хүртэл тасралтгүй хийж гүйцэтгэсэн байна. Уурхайн тоосжилтыг бууруулах усалгаан уурхайн шүүрлийн усыг ашиглаж байна. Уурхайн зам талбайн усалгаанд 2 усалгааны машин өдөр шөнийн ээлжинд тогтмол усалгааны ажлыг гүйцэтгэдэг.

Уурхайн хуримтлагдсан шүүрлийн усанд тоолуур суурилуулж зам талбайн усалгааны зориулалтаар ашигласан усны төлбөрийг тоолуурын заалтаар холбогдох газруудад төлж байна. Уурхайгаас гарах шүүрлийн зам талбайн усалгаанд ус хангалттай хүрэлцээтэй бөгөөд тухайн шүүрлийн усанд стандартын шаардлагатай хангасан тоолуур тавьж ашигладаг.



Зураг 8. Уурхайн дотоод зам талбайн усалгаа хийгдсэний дараа
Уурхайн зам талбайн тоосжилтыг бууруулах усалгааны зориулалтаар уурхайн шүүрлийн уснаас 21918м³, худгийн уснаас 1811м³ тус тус ашигласан байна.



Зураг 9. Шүүрлийн ус №01



Зураг 10. Технологийн худаг №02



Зураг 11. Уурхайн шүүрлийн усыг тусгай зумп байгуулж хуримтлуулан ашигласан байдал

Хүснэгт 8. Уурхайн шүүрлийн болон худгаас 1-10 сард усалгаанд ашигласан усны хэмжээ

Сар	Худгийн нэр	Эхэлсэн тоолуурын заалт, м ³	Дууссан тоолуурын заалт, м ³	Тухайн сар ашигласан ус, м ³	Замын усалгаанд ашигласан ус, м ³
01 сар	Технологи худаг	--	-	-	-
02 сар	Технологи худаг	-	-	183	183
03 сар	Шүүрлийн ус	00000	-	720	1183
	Технологи худаг	-	-	463	
04 сар	Шүүрлийн ус	-	-	3760	3992
	Технологи худаг	-	-	232	
05 сар	Шүүрлийн ус	14820	20733	5913	6058
	Технологи худаг	-	-	145	
06 сар	Шүүрлийн ус	20733	26600	5867	5948
	Технологи худаг	000	0081	81	
07 сар	Шүүрлийн ус	26600	28056	1456	1462
	Технологи худаг	0081	0087	6	
08 сар	Шүүрлийн ус	28056	28804	748	1103
	Технологи худаг	00087	00442	355	
	Шүүрлийн ус	28804	032368	4312	4698

09 сар	Технологи худаг	00442	00828	386	
10 сар	Шүүрлийн ус	032368			
	Технологи худаг	00828			
			22	1811	024627



График 1. Хашаатын цав уурхайн тоосжилтонд ашигласан худгийн болон шүүрлийн ус

- **Тоосжилт үүсэхээс сэргийлж хурдны хязгаарлалтыг мөрдөн ажиллах, хүчтэй салхи шуургатай үед уурхайн ажиллагааг түр зогсоох, уурхайн тоосжилтыг тогтмол хэмжих**

Хашаатын цав уурхайн дотоод замын хөдөлгөөнийг зохицуулах, дагаж мөрдөх журмын дагуу хөдөлгөөний хурдыг зохицуулдаг. Уурхайн тээврийн дотоод замын засвар үйлчилгээ, усалгаа хийж, тухайн замуудад мөрдөх хурдны тодорхой хязгаарыг тогтоон түүнийг баримтлан ажилладаг.



Зураг 12. Уурхайн дотоод тээврийн хөдөлгөөний хурдны хязгаар



Зураг 13. Уурхайн хотхоноос уурхай орох замын хайрган дэвсэлт хийгдсэн байдал



Зураг 14. Уурхайн дотоод тээврийн замд дэвсэлт болон усалгаа хийгдсэн байдал

2. Агаарын тоосжилтын шинжилгээний давтамжийг нэмэх, тогтмол хэмжилт хийх үр дүнд үндэслэсэн арга хэмжээг цаашид хэрэгжүүлэх
Уурхайн агаарын шинжилгээний хяналтын 8 цэгт агаарын тоосжилтын гэрээт эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн хяналт болон гүйцэтгэгч компаниуд сар бүр тоосжилтын түвшин ямар байгааг тогтмол хянаж ажиллаж байна.



Зураг 15. Уурхайн тоосжилтыг хэмжих мэргэжлийн байгууллага уурхайд ажиллаж байгаа нь

5.2. Газрын гадарга, газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Төслөөс газрын гадарга, газрын хэвлийд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл нь уул уурхайн үйл ажиллагаанаас үүсэлтэй газрын эвдрэл, мөн техник хэрэгсэл, тээврийн нөлөөгөөр газрын бүрхэвч элэгдэх, олон салаа зам гарч доройтох нөлөөгөөр их хэмжээгээр газрын эвдрэл үүсэх, тоосжилтоор, хөрс дарагдах хучигдах газрын гадаргын ухааш үүсэх, газрын эвдрэл нөлөөллүүд болж байна. Хашаатын цав уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр 2023 онд нэмж газар эвдрэлд ороогүй байна. Уурхайн олборлолтын үйл ажиллагаанд 80.0 га, хөрсний овоолго 144.0 га, засвар үйлчилгээний талбай пүү, дэд бүтцийн 114.1 га, шимт хөрсний овоолго 29.0 га, газрын эвдрэлд орсон байна. 2023 оны БОМТ-нд газрын гадаргын хэвлий, хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах нийт 4 арга хэмжээ төлөвлөсөн бөгөөд хэрэгжилтийг дараах хүснэгтэд харуулсан болно.

Хүснэгт 9. Газрын гадарга, газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний гүйцэтгэл

Болзошгүй нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	Хэрэгжүүлсэн ажил
Ил уурхайгаас хуулсан хөрсийг 294.6 га талбайд Хаягдал чулуулгийн овоолго үүсгэн газрын гадаргын төрхийг өөрчлөх	Овоолгын ерөнхий налууг <22о байхаар тооцож гадаргууг тогтворжуулах	Уурхайн хөрсний овоолгын налууг 22о байхаар төлөвлөн хөрсний овоолго үүсгэн хадгалж байна.
Хаягдал чулуулгийн овоолгоос хүчиллэг урсац үүсэж газрын гадарга хэвлийг бохирдуулах	2023 оны уулын ажлын төлөвлөгөөгөөр карьерын тэлэлтийн хөрс хуулах хийгдэх буй талбайн шимт хөрсийг 40-50 см орчим зузаан хуулах, хадгалах	Уулын олборлолт болон үйл ажиллагаанд шинээр өртөх тухайн талбайнуудын шимт хөрсний тусгайлан хуулж, шимт хөрсний талбайд зөөж хадгалж байна. Одоогийн байдлаар 16 га талбайд шимт хөрс хадгалж байна.
Уурхайн тосгон, уурхайн оффисоос гарсан хатуу, шингэн хог хаягдлаар газрын гадарга, хэвлийг бохирдуулах	Төслийн үйл ажиллагаанаас гарах хатуу хог хаягдлыг зориулалтын нэгдсэн цэгт цуглуулж, зайлуулах оператор компаниудын хог хаягдлын талбайг хатуу хучилттай болгох, түүнд хяналт тавих, хог хаягдлыг бүртгэлжүүлэх	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлтийн хэсэгт хог хаягдлын талаар хийгдсэн ажлын талаар дэлгэрэнгүй харж болно.
“Тэрбум мод” хөтөлбөрийн хэрэгжилт	Тэрбум мод хөтөлбөрийн дагуу уурхайд болон Баянтүмэн сумын нутагт мод тарих ажлыг гүйцэтгэх	“Тэрбум мод”-ны хөтөлбөрийн талаар нөхөн сэргээлтийн хэсэгт тусгасан болно.

1. Овоолгын ерөнхий налууг 22о байхаар тооцож гадаргууг тогтворжуулах

Ил уурхайгаас хуулсан хөрсийг хөрсний чулуулгийн овоолго үүсгэж, уурхайн хөрсний овоолгын налууг 35-37 градус байхаар төлөвлөн одоогийн байдлаар 144.0 га талбайд 35,917,321м³ хөрсний овоолго үүсгэн хадгалж байна.



Зураг 16. Уурхайн хөрсний гадаад овоолго

2. 2023 оны уулын ажлын төлөвлөгөөгөөр карьерын тлэлтийн хөрс хуулах хийгдэх буй талбайн шимт хөрсийг 40-50 см орчим зузаан хуулах, хадгалах
Уулын олборлолт болон үйл ажиллагаанд шинээр өртөх тухайн талбайнуудын шимт хөрсний тусгайлан хуулж, шимт хөрсний талбайд зөөж хадгалж байна. Уурхайн шимт хөрсний талбай 29.0 га-д байгуулсан бөгөөд 2023 онд шинээр 20,772м³ шимт хөрс хуулж нэмж хадгалсан байна



Зураг 17. Уурхайн шимт хөрсний овоолго

5.3.Гадаргын ус, газрын доорхи усны чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Хашаатын цав уурхайн усны менежментийн хүрээнд уурхайн бүх үйл ажиллагаанд усыг зөв зохистой хэрэглэх, усыг дахин ашиглах, мөн үйл ажиллагаа явуулж буй бүс нутгийн усны нөөц, чанарт учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах байгаль дахь усны нөөц, чанарыг алдагдуулахгүй байхаар ажиллаж байна.

Хашаатын цавын уурхайн усан хангамжийн үндсэн эх үүсвэр нь гүний худаг болон уурхайгаас гарч буй шүүрлийн ус юм. Усны тухай хуулийн 28.2-т заасанчлан 2023 оны ус ашиглуулах дүгнэлтийг “Усны Газар” ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлагаас тухайн жилийн ус ашиглах төлөвлөгөөнд дээр үндэслэн ус ашиглах хэмжээг зориулалт тус бүрээр тооцоолон ус ашиглах дүгнэлтийн дагуу ашиглалт явуулж байна. 2023 оны БОМТ-нд гадаргын болон гүний усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах 4-н арга хэмжээ төлөвлөсөн бөгөөд хэрэгжилтийг дараах хүснэгт -д товч байдлаар дурдав.

Хүснэгт 10. Гадаргын ус, газрын доорхи усны чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Газрын доорхи ус, гадаргын усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Болзошгүй нөлөөлөл	Газрын доорхи ус, гадаргын усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	Биелэлт
Хашаатын цав хүрэн нүүрсний уурхай орчмын газрын доорх усны түвшин буурч, нөөц багасах	<ul style="list-style-type: none"> Уурхайн ус шавхах цооногийн байршлыг оновчтой сонгож усан сан байгуулах, тухайн усан санд усны нэвчилт хамгийн бага байхаар филонк дэвсэх, тухайн шүүрлийн ус ашиглалтын бүрэн хянах, бүрэн тоолууржуулах Уурхайн технологийн усны хэрэглээнд хяналт тавьж, сар бүрийн мэдээг гарган орон нутгийн байгаль орчны хяналтын улсын байцаагчид хүргүүлж байх, ус ашигласны төлбөрийг тухайд бүрд барагдуулах 	Уурхайн ус шавхах цооногийн байршлыг уурхайгаас гүнээс дээш өндрийн түвшинд шүүрлийн ус хуримтлуулах усан сан 0.7 га талбайд байгуулсан. Тухайн усан сангаас дээшээ газрын гадаргад ус зайлуулах ус шүүх 3-н сангаар дамжиж шүүрлийн ус уурхайгаас зайлуулж байна. Тухайн 2-р сангаас зам талбайн усалгаанд ус ашиглаж байна. Уурхайн усны эх үүсвэрүүд бүгд тоолууртай ашиглаж байна.
Газрын доорхи усанд уурхайн нөлөөлөл үзүүлэх нөхцлийг судлах, мониторинг хийх	<ul style="list-style-type: none"> Уурхайн хяналтын цооног гаргах, хяналтын худгийн усны түвшинд мониторинг хийж, дүгнэлт гаргах 	Тухайн ажил энэ жил хийгээгүй болно.
Усны эх үүсвэрийг хамгаалах ус ашиглах гэрээний үүрэгт ажил	<ul style="list-style-type: none"> Хэрлэн голын сав газраас тогтоож өгсөн Булаг шандын эхийг хашиж хамгаалах ажил 	Усны гэрээний дагуу тухайн бүс нутагт орших “зуухтын булаг”-ийн эхийг хашиж хамгаалсан.
Уурхайн үйл ажиллагааны үед техник хэрэгслийн засварын газар, ШТС зэргээс ШТМ газрын хөрсөнд алдагдах, улмаар хур борооны усаар угаагдан газрын хэвлийд шингэн газрын доорх болон гадаргын усыг бохирдуулах болзошгүй	<ul style="list-style-type: none"> Уурхайн дэвсгэрийн засварын үйлчилгээ хийх талбайнууд, аюултай хаягдлуудыг хадгалах тодорхой талбайнуудад хяналт тавих, хатуу хучилттай болгох 	Уурхайн засвар үйлчилгээний талбайн техникүүдийн зогсож засвар үйлчилгээ хийгдэх тодорхой талбайнуудад хатуу хучилт болон хайрган дэвсэлт хийгдсэн болно.

1. Уурхайн ус шавхах цооногийн байршлыг оновчтой сонгож усан сан байгуулах, тухайн усан санд усны нэвчилт хамгийн бага байхаар филонк дэвсэх, тухайн шүүрлийн ус ашиглалтын бүрэн хянах, тоолууржуулах

Уурхайн газрын доорх шүүрлийн усыг уурхай дотор зумп байгуулж тухайн зумпэд шүүрүүлж хуримтлагдсан усыг хоёр насосын тусламжтайгаар /насос нь 630м³/цаг болон 180м³/цаг ус сорох хүчин чадалтай 2насос/ тухайн усыг дээшээ 2-р усан сангийн талбайд ус хуримтлуулах ажил хийгдсээр байна. Тухайн ус сангаас зам талбайн усалгаанд тоолуур тавьж ашиглаж байна.



Зураг 18. Уурхайн шүүрлийн ус хуримтлуулсан зумп байгуулсан байдал

2. Уурхайн технологийн усны хэрэглээндээ хяналт тавьж, сар бүрийн мэдээг гарган орон нутгийн байгаль хамгаалагч, татварын байцаагч нарт хүргүүлж байх, ус ашигласны төлбөрийг тухайд бүрд барагдуулах

Хашаатын цав уурхайн зам талбайн тоосжилтыг бууруулах усалгааг шүүрлийн уснаас ханган ажилладаг. Тус зам талбайн усалгаанд ашиглах шүүрлийн усанд LXLG-150 маркийн 250 м³/цаг хэмжих хязгаартай, 150 мм голчтой №2110004976 дугаартай тоолуурыг 1-р лац №021, 2-р лац дугаар MGL0541910 дугаартай битүүмжилсэн 0014820 заалттай) 2023 оны 05 сарын 03-нд тоолуур тавьсан байсан. Тухайн тоолуурын заалтын дагуу сар бүр Баянтүмэн байгаль хамгаалагч, татварын байцаагч, сав газрын мэргэжилтэн нар ирж тоолуурын заалтыг шалгаж тогтмол хяналт тавьдаг.

Хүснэгт 11. Хашаатын цав уурхайн технологийн шүүрлийн усны тоолуурын заалтын баталгаажуулалт

Тоолуурын дугаар	Тоолуурын заалт баталгаажуулсан огноо	Тоолуурын заалт	Ашигласан усны хэмжээ, м ³
№2110004976	2023.05.03	014820 м ³	1025
	2023.05.27	03576 м ³	2551

	2023.06.28	05562м ³	1986
	2023.07.30	07762м ³	2060
	2023.08.29	07858м ³	236
	2023.09.30	07858м ³	0
	2023.10.30	07858м ³	0
	2023.11.25	07858м ³	0
Нийт хэрэглээ		7858м³	7858

Хүснэгт 12. Хашаатын цав уурхайн технологийн худаг №02 усны тоолуурын заалтын баталгаажуулалт

Тоолуурын дугаар	Тоолуурын заалт баталгаажуулсан огноо	Тоолуурын заалт	Ашигласан усны хэмжээ, м ³
№2107134902	2023.05.03	38 м ³	38
	2023.05.27	244 м ³	244
	2023.06.28	145	145
	2023.07.30	81	81
	2023.08.29	6 м ³	6
	2023.09.30	355 м ³	355
	2023.10.30	386 м ³	386
	2023.11.25	0 м ³	0
2023 оны 10 сарын байдлаар ус		001641 м³	1641



2023.05.03-ны уурхайн шүүрлийн усанд тоолуур суурилж байгаа байдал



2023.06.27-ны уурхайн шүүрлийн усны тоолуур баталгаажуулалт



2023.07.26-ны уурхайн шүүрлийн усны тоолуур баталгаажуулалт



2023.08.26-ны уурхайн шүүрлийн усны тоолуур баталгаажуулалт



2023.10.02-ны уурхайн шүүрлийн усны тоолуур баталгаажуулалт

Уурхайн ус ашиглалт 2023 оны 5-10 сарын хугацаанд уурхайн шүүрлийн уснаас 18296м³ ус, технологийн худгаас 1822м³ уурхайн зам талбайн тоосжилтыг бууруулах зорилгоор, зам талбайн усалгааны зориулалтаар/1255+18296м³/ашигласан байна. 2023 оны 11 сарын байдлаар үйлдвэрийн зориулалтаар ашигласан усны төлбөрт нийт 10,541,777.4 төгрөг төлсөн байна.

Хүснэгт 13. Хашаатын цав уурхайн шүүрлийн уснаас зам талбайн усалгааны зориулалтаар ашигласан усны төлбөр

Сарын ус ашиглалт	Ашигласан усны төлбөр,төг	Нийт усны төлбөр, төгрөг
05 сарын ус ашиглалт	6812 м ³ *510.3	3,476,163.6
06 сарын ус ашиглалт	4968 м ³ *510.3	2,535,170.4
07 сарын ус ашиглалт	1456 м ³ *510.3	742,996.8

08 сарын ус ашиглалт	748 м ³ *510.3	381,704.4
09 сарын ус ашиглалт	4312 м ³ *510.3	2,200,413.6
10 сарын ус ашиглалт	м ³ *510.3	0,000,00
Нийт ус		9,718,153.2

Хүснэгт 14. Хашаатын цав уурхайн технологийн худгийн уснаас зам талбайн усалгааны зориулалтаар ашигласан усны төлбөр

Сарын ус ашиглалт	Ашигласан усны төлбөр, төг	Нийт усны төлбөр, төгрөг
03 сарын ус ашиглалт	38 м ³ *510.3	19,391.4
04 сарын ус ашиглалт	244 м ³ *510.3	124,513.2
05 сарын ус ашиглалт	145 м ³ *510.3	381,704.4
06 сарын ус ашиглалт	81 м ³ *510.3	41,334.3
07 сарын ус ашиглалт	6 м ³ *510.3	0,000,00
08 сарын ус ашиглалт	355 м ³ *510.3	184,218,3
09 сарын ус ашиглалт	386 м ³ *510.3	196,975.8
10 сарын ус ашиглалт	0 м ³ *510.3	000,000
Нийт ус		823,624.2

3. Уурхайн хяналтын цооног гаргах, хяналтын худгийн усны түвшинд мониторинг хийж, дүгнэлт гаргах

Уурхайн гидрогеологийн судалгаанд үндэслэн уурхайн хяналтын цооног байгуулах ажил төлөвлөсөн хэдий ч тухайн ажил компаний ҮАЗардлын хязгаарлагдмал байдлаас болж тухайн ажлыг гүйцэтгэж чадаагүй байна.

4. Хэрлэн голын сав газраас тогтоож өгсөн Булаг шандын эхийг хашиж хамгаалах ажил

Хэрлэн голын сав газартай “Ус ашиглах” гэрээний дагуу Баянтүмэн сумын 2 дугаар багийн нутагт уурхайгаас баруун хойд зүгт ойрхон орших Зуухтын булгийг хашиж хамгаалах үүрэгт ажил өгсний дагуу тухайн булагт 10м*9.0м харьцаатай 2 хашаа барьж тухайн булгийн ундаргатай 2 эхийг хашаа татаж хамгаалах ажлыг гүйцэтгэсэн.



Зураг 1. Хамгаалах шаардлагатай Зуухтын булгийн ундаргатай хоёр эх Зуухтын булаг Дорнод аймгийн Баянтүмэн сумын нутагт Хэрлэн голын дагуу аймгийн төвөөс 30 орчим км, “Хашаатын цав” хүрэн нүүрсний уурхайгаас 50 орчим км-н зайтай тус булаг 3-н салаалсан эхээс бүрдэж урсдаг ба Хэрлэн голыг тэжээдэг байна. Тус

булгийн ундарга ихтэй 2 эхийг хашиж хамгаалах ажлыг гэрээний үүргийн дагуу “Меланж” ХХК нь 2023.09.10-09.15 хооронд тухайн ажлыг гүйцэтгэсэн болно.



Зураг 2. Булгийн талбай дээр хашаа барьж байгаа байдал

5. Уурхайн дэвсгэр дэх ШТС, Засварын газар, явуулын цистерн зэрэг ШТМ алдагдаж болзошгүй эх үүсвэрүүд болон уурхайн хүнд машин техник, тээврийн хэрэгслүүдийн бүрэн бүтэн байдлыг өдөр бүр шалгах

Уурхайн шатахуун түгээх станц, засвар үйлчилгээний газар, явуулын цистерн зэрэг ШТМ алдагдаж болзошгүй эх үүсвэрүүд тогтмол хяналт тавьж ажилладаг учраас одоогоор ямар асгаралт, алдагдах тохиолдол бүртгэгдээгүй болно.

5.4.Хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Хүснэгт 15. Хөрсөнд бүрхэвчинд нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Болзошгүй нөлөөлөл	Хөрсөн брхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	Хэрэгжүүлсэн ажил
Хөрсөн болон газрын бүрхэвч		
Хөрс хуулалт хийх, зам талбай гаргах, нүүрс тээвэрлэх, ачиж буулгах үйл ажиллагааны үед тухайн орчны өнгөн хөрс элэгдэх, үржил шимт чанар нь алдагдах	Уулын ажлын төлөвлөгөөгөөр карьерын тэлэлт хийгдэх буй талбайн шимт хөрсийг тухайн газрын гадаргын хэв шинжийн онцлогоос хамааран 20-40 см орчим зузаан хуулж, овоолго үүсгэн хэлбэржүүлж хадгалан, хамгаалах, ургамалжуулах ажил хийх	Уурхайн үйл ажиллагаанд өртөх талбайнуудад үйл ажиллагаанд өртөхөөс өмнө тухайн талбайн шимт хөрсийг хөрсийг 0.2 метр зузаантай 5 метрээс ихгүй өндөртэй овоолго үүсгэн хадгалж байна.
Уурхайн үйл ажиллагаатай холбоотой тээврийн хөдөлгөөнөөр олон салаа зам үүсч улмаар хөрсний эвдрэл, доройтол бий болох	Замын нэгдсэн системтэй болж хурдны хязгаар, чиглэлийг заасан замын тэмдгүүдийг замын салаа, уулзварууд, холбогдох газарт байршуулах	Замын нэгдсэн системтэй болж хурдны хязгаар, чиглэлийг заасан замын тэмдгүүдийг замын салаа, уулзварууд шаардлагатай газруудад тэмдэг байрлуулсан.
Бензин, тос, дизель (шатах тослох материал) зэргийн асгаралт, уурхайн засвар үйлчилгээний ашигласан тос, тосолгооны материалын асгаралт үүсч хөрсний бохирдол үүсгэх	ШТМ-аар бохирдсон хөрсийг тээвэрлэн уурхайн бохирдсон хөрс цуглуулах талбайд хүргэх, тусгайлан хуримтлуулах	Уурхайн нутаг дэвсгэр ШТС, Засварын газар, явуулын цистерн зэрэг ШТМ алдагдаж болзошгүй эх үүсвэрүүд тогтмол хяналт тавьж асгарсан тохиолдолд тухайн бохирдсон хөрсийг хуулж цэвэрлэгээ хийгддэг. ШТС-ын талбайн түлшний агуулах хатуу хучилттай болгож хөрсний бохирдол үүсэхээс хамгаалсан. Засвар үйлчилгээний талбайд хөрсний бохирдлоос хамгаалсан 2-3 м зузаан хөрсөөр дэвсэлт хийгдсэн.
	Засвар үйлчилгээний талбайнуудын аюултай хаягдал болох ашигласан тос, маслын хаягдал түр хадгалах агуулах, талбай болон засвар үйлчилгээ хийх тодорхой талбайнуудыг хатуу хучилттай болгох	Уурхайн засвар үйлчилгээний талбайнуудын шаардлагатай техникийн засвар үйлчилгээ хийгдэх газруудад хатуу хучилттай тавцан байршуулсан. Мөн хайрган дэвсэлт хийж хамгаалсан.

1. Уулын ажлын төлөвлөгөөгөөр карьерын тэлэлт хийгдэх буй талбайн шимт хөрсийг тухайн газрын гадаргын хэв шинжийн онцлогоос хамааран 20-40 см орчим зузаан хуулж, овоолго үүсгэн хэлбэржүүлж хадгалан, хамгаалах, ургамалжуулах ажил хийх

Уурхайн үйл ажиллагаанд өртөх талбайнуудад үйл ажиллагаанд өртөхөөс өмнө тухайн талбайн шимт хөрсийг хөрсийг 30-40 см зузаантай 5 метрээс ихгүй өндөртэй овоолго үүсгэн хадгалж байна. Нийт 2023 оны 11 сарын байдлаар 29.0 га талбайд шимт хөрсний

овоолго байгуулан хадгалж байгаа тухайн жилд шимт хөрс хуулах ажил харьцангуй бага хийгдсэн буюу 20,772 м³ шимт хөрс хуулагдсан байна.



Зураг 19. Уурхайн шимт хөрсний овоолго

2. Замын нэгдсэн системтэй болж хурдны хязгаар, чиглэлийг заасан замын тэмдгүүдийг замын салаа, уулзварууд, холбогдох газарт байршуулах

Замын нэгдсэн системтэй болж хурдны хязгаар, чиглэлийг заасан замын тэмдгүүдийг замын салаа, уулзварууд шаардлагатай газруудад тэмдэг байрлуулсан.

3. ШТМ-аар бохирдсон хөрсийг тээвэрлэн уурхайн бохирдсон хөрс цуглуулах талбайд хүргэх, тусгайлан хуримтлуулах

Уурхайн нутаг дэвсгэр ШТС, засварын газар, явуулын цистерн зэрэг ШТМ алдагдаж болзошгүй эх үүсвэрүүд тогтмол хяналт тавьж асгарсан тохиолдолд тухайн бохирдсон хөрсийг хуулж цэвэрлэгээ хийдэг. Засвар үйлчилгээний талбайд хөрсний бохирдлоос хамгаалсан 2-3м зузаан хөрсөөр дэвсэлт хийж том оврын техникүүдэд засвар үйлчилгээ хийгдэх тодорхой талбайнуудад хайрган болон хатуу цементэд хавтангууд байршуулсан.

Уурхайн бохирдсон хөрсийг тусгайлан бохирдсон хөрс хуримтлуулах талбайд тусгайлан хуримтлуулан хадгалж байна.



Зураг 20. Уурхайн засвар үйлчилгээний талбайнуудад хөрс хийж хамгаалсан байдал



Зураг 21. Уурхайн засвар үйлчилгээний хэсэгт хайрга давхар хийж байгаа байдал талбайг хатуу хучилт хийж хөрсний бохирдлоос хамгаалсан байдал



Зураг 22. Уурхайн засвар үйлчилгээний зарим хэсэгт байршуулсан хатуу хучилт

5.5. Ургамлан нөмрөг, амьтаны нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Уурхайн орчмын ургамлын нөмрөг нь олборлолт болон уурхайн дэд бүтцийн үйл ажиллагаанд өртөж учраас дунд хэмжээний талхагдалд орж нөлөөлөлд орсон тухай газрын төлөв байдал хянан баталгаагаар тодорхойлсон. Уурхайн үйл ажиллагаанаас ургамлын бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахын тулд газар хөндөлтийн хяналт, олон салаа зам гаргахгүй байх тогтсон нэг маршрутаар техник хэрэгслүүдээ явуулах, уурхайн дотоод замыг тэмдэгжүүлэн ялгах, уурхайн кемпийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлуудыг хэрэгжүүлж байна.

Хүснэгт 16. Ургамлан нөмрөг, амьтны аймагт нөлөөллөх байдлыг бууруулах арга хэмжээний зөвлөмж

Болзошгүй нөлөөлөл	Амьтан, ургамлын үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	Биелэлт
Гэр утас: (976)-88010503, (976)-91010503
Web: www.en-andlt.com
E-mail: d.bolbol@bolbol.com

Төрийн _____ нс № _____

"Меланж" ХХК-Д

Байгаль орчны төлөвлөгөөт аудитын
дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх тухай

Удиртгал:
"Ногоон гэрэлт ирээдүй" ХХК болон "Меланж" ХХК-ийн хооронд 2023 оны 10-р сарын 10-ны өдөр байгуулсан № Ме-С-23/42 тоот "Байгаль орчны төлөвлөгөөт аудит хийх, ажил гүйцэтгэх гэрээ"-ний дагуу Дорнод аймгийн Баянтүмэн сумын нутагт орших "Хашаатын цав нэртэй хүрэн нүүрсний ордыг ил аргаар ашиглах төсөл"-ийн үйл ажиллагаанд нийцлийн болон гүйцэтгэлийн аудитыг "Ногоон гэрэлт ирээдүй" ХХК-ийн Байгаль орчны аудитын баг Монгол Улсын "Байгаль орчныг хамгаалах тухай хууль"-ийн 10-д зүйлийн дагуу, Байгаль орчны, аялал жуулчлалын сайдын 2019 оны 12 дугаар 25-ны өдрийн А/809 тоот тушаалаар батлагдсан "Байгаль орчны аудит хийх ерөнхий аргачлал" болон компанийн өөрийн боловсруулсан нарийвчилсан арга зүйг мөрдлөг болгон ажиллав. Аудитын үр дүнг үнэлэхэд нийцэл, үл нийцэл, сайжруулах шаардлагатай болон хугацаа болоогүй гэсэн 4 үнэлэмжийг ашигласан.

Аливаа нотолгоогоор гүйцэтгэл нь батлагдсан тохиолдолд нийцэл, батлагдаагүй тохиолдолд үл нийцэл, хууль эрх зүйн хүрээнд болон гүйцэтгэлийн шатанд үр дүн нь тодорхойлогдох болоогүй эсвэл тухайн шалгуур бодит шалтгааны улмаас гүйцэтгэл нь түр хойшлогдсон тохиолдолд хугацаа болоогүй гэсэн үнэлэмжийг хамааруулав.

Аудитын зорилго:
"Меланж" ХХК-ийн Дорнод аймгийн Баянтүмэн сумын нутагт орших "Хашаатын цав нэртэй хүрэн нүүрсний ордыг ил аргаар ашиглах төсөл"-ийн

Байгаль орчны төлөвлөгөөт аудит хийгдсэнээр байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй аргаар үйлдвэрлэл явуулахад туслах, тэднийг учирч болох алдагдал, хохирлоос урьдчилан сэргийлэх үүднээс байгаль орчны хууль тогтоомж, төрийн бодлого, үндэсний хөтөлбөрийн биелэлт, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний хэрэгжилт, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл, стандартын хэрэгжилтийг хянаж, дүгнэлт гаргах, мэргэжлийн зөвлөгөө өгөхөд аудитын зорилго оршино. Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг үндсэн 8 чиглэлд хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Хуулийн нийцэл;
2. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, менежментийн төлөвлөгөө, мониторингийн ажлын гүйцэтгэл
 - 2.1. Усан орчны менежмент;
 - 2.2. Агаар орчны менежмент;
 - 2.3. Хөрсөн бүрхэвч ба техникийн нөхөн сэргээлтийн менежмент;
 - 2.4. Ургамал нөмрөг ба биологийн нөхөн сэргээлтийн менежмент;
 - 2.5. Биологийн олон янз байдлын менежмент;
- 2.6. Хог хаягдлын менежмент;
 - 2.6.1. Ахуйн хог хаягдал
 - 2.6.2. Аюултай хог хаягдал
 - 2.6.3. Химийн хорт болон аюултай бодисын менежмент зэрэг болно.

Аудитын төрөл:
Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг үндсэн 2 чиглэлээр гүйцэтгэсэн. Үүнд:

1. Байгаль орчны нийцлийн аудит
2. Байгаль орчны гүйцэтгэлийн аудит зэрэг болно.

Аудитын хамрах хүрээ:
Цаг хугацааны хувьд: Нийт 21 хоног
Орон зайн хувьд: Уурхайн үйл ажиллагаа
Бичиг баримтын хувьд: Үйлчлүүлэгч байгууллагаас хангасан бичиг баримтуудын хүрээнд ажилласан. Гуравдагч этгээдээс бичиг баримт аваагүй, аудитын шалгуурт тооцогүй.

Объектын хувьд: Уурхайн бүхэлдээ
Хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын хууль тогтоомж болон стандартыг аудитын шалгуур тогтооход ашигласан. Байгаль орчны багц хуулиудын томоохон өөрчлөлтүүд 2012 оны 5 дугаар сард орж, 2012 оны 6 дугаар сараас хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор аудитын үйл ажиллагааны хууль тогтоомжийн хүчин төгөлдөржилтийн цаг хугацааны хамрагдалт нь 2012 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаагаар хязгаарлахаар тохиролцсон. Энэ удаагийн Байгаль орчны

төлөвлөгөөт аудит нь 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс хойших аливаа хууль тогтоомжийн өөрчлөлт, нэмэлт, шинэчлэл зэрэг нь аудитын шалгуурт хамаарахгүй. Түүнчлэн хүчингүй болсон хууль тогтоомжийн аливаа зүйл заалтыг шалгуур болгохгүй. Гэхдээ аудит хийлгэгч байгууллагын аливаа үйл ажиллагааг тухайн үед хүчин төгөлдөр байсан хууль тогтоомжтой харьцуулах ба үйл ажиллагааг хийснээс хойш бий болсон хууль тогтоомжийн шалгууртай харьцуулж үнэлэмжийг гаргаагүй болно.

Хуулийн этгээдийн хүрээнд: Зөвхөн үйлчлүүлэгч байгууллагын хүрээнд хийгдэх ба туслан гүйцэтгэгч, ханган нийлүүлэгч, бусад гэрээт ажил гүйцэтгэгч нарын үйл ажиллагаанд аудит хийгээгүй. Өөрөөр хэлбэл, үйлчлүүлэгч байгууллагад аливаа бараа материал нийлүүлдэг, үйлчилгээ үзүүлдэг байгууллагын үйл ажиллагаа хамаарахгүй ба тухайн байгууллагын үйлчлүүлэгчид нийлүүлсэн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний гэрээ, бичиг баримтын бүрдэл, нийлүүлсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ, түүний тайлан гэх мэтийг үзээгүй. Дээрх зүйлтс аливаа үл нийцэл илэрвэл түүнийг цаашлуулан гэрээлэгч байгууллагад аудит хийгээгүй тул зөвхөн үл нийцлийг тайландаа тусгаж, түүнд аудит хийлгэхийг зөвлөмж хэлбэрээр оруулж болно.

Аудитад хамрагдаагүй хэсэг:
Тус аудитад дараах зүйлс хамрагдаагүй. Үүнд:
Цаг хугацааны хувьд: Газар дээрх аудит хийснээс хойш хугацаанд болсон аливаа үйл ажиллагаа
Орон зайн хувьд: Уурхайн үйл ажиллагаанаас өөр газарт болсон аливаа үйл ажиллагаа
Бичиг баримтын хувьд: Гуравдагч этгээдээс бичиг баримт аваагүй, аудитын шалгуурт тооцогүй.
Объектын хувьд: Уурхайн үйл ажиллагаа болон туслах үйл ажиллагаанд хамааралгүй аливаа объект

Хууль тогтоомжийн хувьд: 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс хойших аливаа хууль тогтоомжийн өөрчлөлт, нэмэлт, шинэчлэл зэрэг нь аудитын шалгуурт хамаарахгүй. Түүнчлэн хүчингүй болсон хууль тогтоомжийн аливаа зүйл заалтыг шалгуур болгоогүй.

Хуулийн этгээдийн хүрээнд: Үйлчлүүлэгчээс бусад этгээд хамаарахгүй, мөн үйлчлүүлэгчийн туслан гүйцэтгэгч, ханган нийлүүлэгч, бусад гэрээт ажил гүйцэтгэгч нарын үйл ажиллагаанд аудит хийгээгүй.

Аудитын шалгуур:
Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг гүйцэтгэхэд ашигласан үндсэн шалгуур үзүүлэлтүүд төслийн техник эдийн засгийн үндэслэл, шийдвэр, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, түүний хэрэгжилт, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүний биелэлт, өмнө нь гүйцэтгэсэн байгаль орчны аудитын тайлан болон хууль тэдгээртэй нийцүүлэн гаргасан

тогтоомж, дүрэм, журам, заавар, стандарт, норм, норматив, эрхийн актууд, зөвшөөрөл, гэрээ, дүгнэлтэд үндэслэсэн болно.


Байгаль орчны төлөвлөгөөт аудитын хүрээнд нийт 980 шалгуур үзүүлэлтээр байгаль орчны аудитыг гүйцэтгэв. Эдгээрээс 265 нь хамааралгүй, 272 нь хуулийн нийцэл, 33 нь төрийн бодлого, үндэсний хөтөлбөр, 453 нь үндэсний хууль тогтоомж, 294 нь холбогдох дүрэм журам, аргачлал, 140 нь стандартад, 60 нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, байгаль орчны мониторингийн гүйцэтгэлийн хувьд давхардсан байдлаар тусгалаа олсон болно.

Хүснэгт 1. Байгаль орчны аудитын шалгуур үзүүлэлт

№	Үзүүлэлт	Хуулийн нийцэл	Усан орчин	Агаар орчин	Хөрсөн бүрхэвч ба техникийн нөхөн сэргээлт	Ургамал нөмрөг ба биологийн нөхөн сэргээлт	Биологийн олон янз байдал	Ахуйн хог хаягдал	Аюултай хог хаягдал	Химийн хорт болон аюултай бодис	Нийт дүн
1.	Төрийн бодлого, үндэсний хөтөлбөр	0	9	5	3	2	1	9	2	2	33
2.	Үндэсний хууль тогтоомж	272	37	11	10	10	7	35	46	25	453
3.	Дүрэм, журам, аргачлал	0	64	7	8	12	8	32	43	120	294
4.	Стандарт	0	12	10	9	8	0	7	6	88	140
5.	БОННУ болон БОМТ	0	9	13	13	9	8	8	0	0	60
Нийт дүн		272	131	46	43	41	24	91	97	235	980
Үүнээс:											
	Нийцэл	236	106	24	25	24	17	51	61	151	695
	Сайжруулах шаардлагатай	0	4	1	0	1	0	5	4	0	15
	Үл нийцэл	0	0	0	0	0	0	2	3	0	5
	Ханмаралгүй	36	21	21	18	16	7	33	29	84	265

Аудитын үнэлэмж:
Шалгуур бүрийг нотолгоотой үндэслэл үнэлэмжийг боловсруулсан. Нийт нийцлийн болон гүйцэтгэлийн 980 шалгуурт цуглуулсан нотолгоонд дээр түүлүүлэн үнэлэмжийг боловсруулахад дараах байдлаар үнэлэгдэв. Шалгуур үзүүлэлтийн хувийг тооцохдоо хамааралгүй гэсэн үзүүлэлтийг хасаж тооцсон болно.

Аудитын үр дүнгийн үнэлэмжийн бүртгэл:



3.	Агаар орчны менежмент	24	1	0	0	21	46
4.	Харсан бүрхэвч ба техникийн нөхөн сэргээлтийн менежмент	25	0	0	0	18	43
5.	Ургамал нөмрөг ба биологийн нөхөн сэргээлтийн менежмент	24	1	0	0	16	41
6.	Биологийн олон янз байдлын менежмент	17	0	0	0	7	24
7.	Хог хаягдлын менежмент	51	5	0	2	33	91
7.1	- Аюултай хог хаягдал	61	4	0	3	29	97
7.2	- Аюултай хог хаягдал	151	0	0	0	84	235
8.	Хийний хорт болон аюултай бодис	695	15	-	5	265	980
Нийт		97.2	2.1	-	0.7	-	100
Эзлэх хувь /% /		97.2	2.1	-	0.7	-	100

Байгаль орчны аудитын үр дүнгийн нэгтгэлээс үзэхэд нийт 980 асуулгын 695 (97.2%) асуулгад хангалттай буюу хэрэгжилт маш сайн гэсэн үнэлгээ авсан бол нийт 15 (2.1%) асуулгад сайжруулах шаардлагатай, 5 (0.7%) асуулгад үл нийцэл, харин 269 асуулгад хамааралгүй гэсэн үнэлэмжийг авсан бол тодорхойгүй буюу үнэлэх боломжгүй асуудал гараагүй байна.

Хүснэгт 3. Байгаль орчны аудитын үр дүнгийн эрсдэлийн нэгтгэл

№	Байгаль орчны аудитын хамрах хүрээ	Үл нийцлийн эрсдэл				Хэсгийн дүн
		Их	Дунд	Бага	Үгүй	
1.	Хуулийн нийцэл	0	0	0	236	236
2.	Усан орчны менежмент	0	0	4	106	110
3.	Агаар орчны менежмент	0	0	1	24	25
4.	Харсан бүрхэвч ба техникийн нөхөн сэргээлтийн менежмент	0	0	0	25	25
5.	Ургамал нөмрөг ба биологийн нөхөн сэргээлтийн менежмент	0	0	1	24	25
6.	Биологийн олон янз байдлын менежмент	0	0	0	17	17
7.	Хог хаягдлын менежмент	0	2	5	51	58
7.1	- Энгийн хог хаягдлын менежмент	0	3	4	61	68
7.2	- Аюултай хог хаягдлын менежмент	0	0	0	151	151
8.	Хийний хорт болон аюултай бодис	-	-	-	15	15
Нийт		-	5	15	695	715
Эзлэх хувь /% /		-	0.7	2.1	97.2	100

Байгаль орчны аудитын эрсдэлийн нэгтгэлээс үзэхэд нийт 715 асуулгын 695 (97.2%) асуулгад эрсдэл байхгүй, 15 (2.1%) асуулгад бага зэрэг эрсдэлтэй, 5 (0.7%) асуулгад дунд зэрэг эрсдэл үүсэж болохгүй байна.

Аудитын ерөнхий дүгнэлт:

"Меланж" ХХК-ийн Дорнод аймгийн Баянтүмэн сумын нутагт орших "Хашаатын цав нэртэй хүрэн нүүрсний ордыг ил аргаар ашиглах төсөл"-ийн Байгаль орчны төлөвлөгөөт аудит гүйцэтгэсэн үр дүнг үндэслэн дараах нэгдсэн дүгнэлтийг өгч байна. Үүнд:

- Байгаль орчны аудитын үр дүнгийн нэгтгэлээс үзэхэд нийт 980 асуулгын 695 (97.2%) асуулгад хангалттай буюу хэрэгжилт маш сайн гэсэн үнэлгээ авсан бол нийт 15 (2.1%) асуулгад сайжруулах шаардлагатай, 5 (0.7%) асуулгад үл нийцэл, харин 265 асуулгад хамааралгүй гэсэн үнэлэмжийг авсан бол тодорхойгүй буюу үнэлэх боломжгүй асуудал гараагүй байна. Байгаль орчны аудитын үр дүн 97.2%-тай байгаагаас дүгнэхэд үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хуулийн нийцэл болон гүйцэтгэлийн үр дүн "Маш сайн" байгааг харуулж байна.
- "Меланж" ХХК-ийн Дорнод аймгийн Баянтүмэн сумын нутагт орших "Хашаатын цав нэртэй хүрэн нүүрсний ордыг ил аргаар ашиглах төсөл"-ийн Байгаль орчны үйл ажиллагааны 97.2% нь үндэсний хууль тогтоомжид нийцтэй буюу гүйцэтгэлтэй байна. Хугацаа болоогүй буюу тухайн шалгуурыг гүйцэтгэх цаг хугацаа болоогүй байгаа үлд тэдгээрийг шууд үл нийцэл гэж ойлгохгүй бөгөөд тус байгууллага ирээдүйд түүнийг гүйцэтгэн гэдэг итгэлтэй байна. Үл нийцэл нь 0.7% байна. Сайжруулах шаардлагатай буюу аудитын явцад хангалттай мэдээ баримт цуглаагүй, аудит хийлгэгч талаас нотлох баримтаар хангаагүй шалгууруудыг дараагийн төлөвлөгөөт аудит гүйцэтгэх хүртэл хугацаанд нийцэлтэй болгож залруулах боломжтой.
- Байгаль орчны аудитын эрсдэлийн нэгтгэлээс үзэхэд нийт 715 асуулгын 695 (97.2%) асуулгад эрсдэл байхгүй, 15 (2.1%) асуулгад бага зэрэг эрсдэлтэй, 5 (0.7%) асуулгад дунд зэрэг эрсдэл үүсэж болохгүй байгааг цаашид үйл ажиллагаандаа анхаарч ажиллах шаардлагатай.
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 12 дугаар сарын 25-ний өдрийн А/809 тоот тушаалаар батлагдсан "Байгаль орчны аудит хийх ерөнхий аргачлал"-ын дагуу дүгнэвэл: Тус байгууллагын байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, үр дагавар онц уришгатай бус бөгөөд ийддлэг, зохион байгуулалтын тодорхой арга хэрэгжээ болон хууль тогтоомжийн зөвхөн заалтуудыг хангах шаардлагатай. Цаашид сайжруулах шаардлагатай гэсэн шалгууруудыг нийцэлтэй болгохын тулд амьлтын хугацаа тогтоож, холбогдох хүмүүст үүрэг ногдуулах хэрэгтэй. Төслийн үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэх боломжтой.

Ерөнхий зөвлөмж:

Аудит хийгдсэн үндсэн 9 чиглэл тус бүрийн зөвлөмжүүд тайлангийн үл нийцлийг арилгах төлөвлөгөөнд туссан бөгөөд "Меланж" ХХК-ийн зүгээс дараагийн аудитыг хийлгэхдээ чиглэлээ улам өргөжүүлэх нь зүйтэй.

Монгол Улсын Байгаль орчны багц хууль 2012 онд шинэчлэгдэн батлагдсан, тэдгээрийг биелүүлэх журмууд 2012-2023 онуудад батлагдсан гарч байгаа бөгөөд тус компанийн хувьд эдгээр журмын заалтуудыг хэрэгжүүлэх шаардлагатай.

Аливаа хийсэн ажлыг баримтжуулах, түүнийг архивлан хадгалах асуудлыг анхааралдаа авч, үүнийг байгаль орчны мэргэжилтэнд бүрэн харьцуулах хэрэгтэй.

Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ АХЛАХ АУДИТОР

/Д.БАТБОЛД/

4. Байгаль орчны төлөвлөгөөний дагуу хийгдэж буй ажил, талаар ажлын бүтэн, хагас жилийн тайланг Баянтүмэн сумын ЗДТГ-т, аймгийн БОАЖГ-т, БОУХБ-д мэдээлж байх

Байгаль орчны төлөвлөгөөний дагуу хийгдэж буй ажлын тайлангуудыг тухайн байгууллагуудад тухайн үед хүргүүлэн хамтран ажиллаж байна.

12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ АЖЛЫН БИЕЛЭЛТ

Төсөл хэрэгжүүлэгч жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар аймгийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх мөн төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн Баянтүмэн сумын иргэдийн хурлын төлөөлөгч нарыг уурхайд нээлттэй урьж үйл ажиллагааны тайлан болон БОМТ-ний хэрэгжилтийн талаар тайлан танилцуулах арга хэмжээг нээлттэй зохион байгуулж ажилласан.

Тайлан, мэдээ	Тайлан мэдээ хүргүүлэх байгууллага.	Биелэлт
2023 оны БОМТ-г баталгаажуулах, батлагдсан 2023 оны төлөвлөгөө холбогдох газруудад хүргүүлэх	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Уурхайн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖЯамаар 2023.04.24-нд баталгаажуулж авч тухайн батлагдсан төлөвлөгөөг аймгийн БОАЖГазар, Баянтүмэн сумын ЗДТГазар, Хэрлэн голын сав газарт бичгийн хамт хүргүүлж ажилласан.
	Дорнод аймгийн Байгаль Орчин Аялал Жуулчлалын Газар,	
	Баянтүмэн сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч	
2023 оны БОМТ-ний хэрэгжилтийн тайлан, мэдээнүүд.	Байгалт орчин, аялал жуулчлалын яам	Хашаатын цав уурхайн 2023 оны хүрээнд хэрэгжүүлсэн мэдээ, тайланг холбогдох газруудад хүргүүлэн ажилладаг болно. Байгаль орчинтой холбоотой төрийн хяналт шалгалт тухайд бүрд нь ажиллаж зөвлөмж шаардлагатай арга хэмжээнүүдийг авч ажилласан байна.
	Дорнод аймгийн Байгаль Орчин Аялал Жуулчлалын Газар, Хэрлэн голын сав газрын захиргаа, Усны газар	
	Баянтүмэн сумын Засаг даргын Тамгын газар, сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч	
Олон нийтэд үйл ажиллагааны тайлан нээлттэй танилцуулж хэлэлцүүлэх байх	Дорнод аймгийн Баянтүмэн сумын ИНТөлөөлөгчдөд танилцуулах	Дорнод аймгийн Баянтүмэн сумын ИНТөлөөлөгчдөд Меланж ХХК нь Хашаатын цав уурхайн 2 жилийн үйл ажиллагааны тайланг танилцуулах үйл ажиллагааг 2023.10.20-нд зохион байгуулж Баянтүмэн сумын иргэдийн хурлын төлөөлөгч 30 гаруй иргэдий уурхайд урьж үйл ажиллагаа хийсэн ажлын тайланг нээлттэй ил тод танилцуулсан.
	Орон нутаг, багийн иргэд	

1. 2023 оны БОМТ-г баталгаажуулах, батлагдсан 2023 оны төлөвлөгөө холбогдох газруудад хүргүүлэх

Уурхайн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖЯамаар 2023.04.24-нд баталгаажуулж авч тухайн батлагдсан төлөвлөгөөг аймгийн БОАЖГазар, Баянтүмэн сумын ЗДТГазар, Хэрлэн голын сав газарт бичгийн хамт хүргүүлж ажилласан.

2. 2023 оны БОМТ-ний хэрэгжилтийн тайлан, мэдээнүүд

Хашаатын цав уурхайн 2023 оны хүрээнд хэрэгжүүлсэн мэдээ, тайланг холбогдох газруудад хүргүүлэн ажилладаг болно. Байгаль орчинтой холбоотой төрийн хяналт шалгалт тухайд бүрд нь ажиллаж зөвлөмж шаардлагатай арга хэмжээнүүдийг авч ажилласан байна.

 <p>“ХАШААТЫН ЦАВ” ХҮРЭН НҮҮРСНИЙ ИЛ УУРХАЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ЖИЛИЙН ТАЙЛАН</p>  <p>ДОРНОД, БАЯНТҮМЭН СУМ</p>	<p>“ХАШААТЫН ЦАВ” ХҮРЭН НҮҮРСНИЙ УУРХАЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙД ДАХЬ УРГАМЛЫН МОНИТОРИНГ СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН</p>  <p>СУДАЛГААНЫ ТААЙЛАН БОЛОВСРУУЛСАН: “МЕЛАНЖ” ХХК-НИЙ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН АБОЛАТ</p> <p>“ХАШААТ ЦАВ” УУРХАЙ</p>	
 <p>ДОРНОД АЙМГИЙН БАЯНТҮМЭН СУМЫН НУТАГТ ОРШИХ МУ-020936 ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БУХИЙ “МЕЛАНЖ” ХХК-НИЙ “ХАШААТЫН ЦАВ” ХҮРЭН НҮҮРСНИЙ ИЛ УУРХАЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭНД ГҮНЖЭГДЭН ӨНӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫН ТАЙЛАН</p>  <p>ДОРНОД АЙМАГ</p>	 <p>“ХАШААТЫН ЦАВ” ХҮРЭН НҮҮРСНИЙ ИЛ УУРХАЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН “ЗУУХТЫН БУЛАГ”-ИЙН ЭХНИЙГ ХАШИЖ ХАМГААДСАН АЖЛЫН ТАЙЛАН</p>  <p>“ХАШААТ ЦАВ” УУРХАЙ</p>	 <p>ДОРНОД АЙМГИЙН БАЯНТҮМЭН СУМЫН НУТАГТ ОРШИХ МУ-020936 ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БУХИЙ “ХАШААТЫН ЦАВ” ХҮРЭН НҮҮРСНИЙ ИЛ УУРХАЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАЙЛАН</p>  <p>“ХАШААТ ЦАВ” УУРХАЙ</p>

3. Олон нийтэд үйл ажиллагааны тайлан нээлттэй танилцуулж хэлэлцүүлэх байх

Дорнод аймгийн Баянтүмэн сумын ИНТөлөөлөгчдөд “Меланж” ХХК нь Хашаатын цав уурхайн 2 жилийн үйл ажиллагааны тайланг танилцуулах үйл ажиллагааг 2023.10.20-нд зохион байгуулж Баянтүмэн сумын иргэдийн хурлын төлөөлөгч 30 гаруй иргэдий уурхайд урьж үйл ажиллагаа хийсэн ажлын тайланг нээлттэй ил тод танилцуулсан.



14. ОРЧНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Дорнод аймгийн Баянтүмэн сумын нутагт МУ-020936 тус тусгай зөвшөөрөл бүхий хүрэн нүүрсний ил уурхайн ашиглалт, олборлолтыг 2021 оны 12 сараас эхлэн явуулж байна. 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг сар бүр, улирал тутам мөн мэргэжлийн байгууллагын хөндлөнгийн хяналтыг жилд 2 удаа хэрэгжүүлэн зохион байгуулахаар журамд тусгагдсны дагуу тухайн хяналтыг 7 сард, 10 сард гүйцэтгэсэн байна.

7 сарын орчны хяналт шинжилгээний ажлыг 2023.07.16-07.18-ны хооронд “Хашаатын цав”-ын хүрэн нүүрсний уурхайн хяналтын цэгүүдэд Улаанбаатар хотоос байгаль орчны мэргэжлийн байгууллага болох “Экологийн бүтэмж” ХХК-ний мэргэжлийн баг бүрэлдэхүүн хийж гүйцэтгэсэн. 07-10 дугаар сарын хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд Агаарын чанарын хяналт шинжилгээ, гүний худгийн болон шүүрлийн усны хяналт-шинжилгээ, хөрсний хяналт шинжилгээ, ундны ахуйн усны чанарын хяналт хүрээнд хийгдсэн болно.

Хяналт-шинжилгээний дээж, сорьцыг МУ-ын итгэмжлэгдсэн лабораториудад батлагдсан аргазүй, стандартын дагуу шинжлүүлсэн. Хөрс, усны дээжийг шинжилгээг “Инженер Геофизи” ХХК -ний хөрс судлалын лаборторид, хөрсний хүнд металлын шинжилгээг “Хан лаб” хөрсний итгэмжлэгдсэн лаборторид Байгаль орчны шинжилгээний лаборторид тус тус шинжилгээ хийгдсэн болно.

Хүснэгт 21. “Хашаат цав”-ын хүрэн нүүрсний ил уурхайн агаарын чанарын хяналтын цэгүүд

Гүйцэтгэгч компани	Шинжилгээ явуулах төрөл, арга хэлбэр	Хяналтын цэгүүд	Арга, аргачлал	Хугацаа	Мэргэжлийн байгууллага
“Хашаатын цав” уурхай	Агаарын чанар (нийт Тоосжилт, NO ₂ , SO)	<ul style="list-style-type: none"> Уулын карьер Засварын талбай Тээврийн зам Гадаад овоолго Шимт хөрс Кемп 	Автомат багаж DUST TRACK-8520	2023.07.20	“Экологийн бүтэмж” ХХК
“108 ойл” ХХК	Агаарын чанар (нийт Тоосжилт, NO ₂ , SO)	<ul style="list-style-type: none"> ШТС 	Автомат багаж DUST TRACK-8520	2023.07.20	“Экологийн бүтэмж” ХХК

АГААРЫН ЧАНАРЫН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ

Агаарын чанарын хэмжилт хийхийн ач холбогдол нь уурхайн тоосжилтыг бууруулах арга хэмжээг тухай бүрт төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг авч ажиллахад оршдог. Үүний тулд үйл ажиллагаа явагдаж буй хугацаанд тасралтгүй мониторинг хийж, суурь мэдээг цуглуулах шаардлагатай. Тус тайланд уурхайн үйл ажиллагаанаас гаралтай агаарын тоосжилтын түвшинг тогтоох зорилготой агаарын дотоодын хяналтын үйл ажиллагаа, үр дүнгийн талаар тусгасан.

Хэмжилтийн арга зүй:

Агаарын чанарын хяналтанд агаар дахь тоосонцорын ширхэглэгт хэсгийг тоолох зарчимд суурилсан өндөр нарийвчлалтай шууд хэмжилтийн төхөөрөмж ашиглан гүйцэтгэж байна. Хашаатын цав уурхайн ширхэглэгт тоосонцорыг хэмжиж үр дүнг Монгол улсын стандарт (MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага; MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага)-тай харьцуулан дүгнэж байна.

Уурхайн орчны хяналтын цэгүүдэд агаарын тоосжилтыг /20 минутын турш/АНУ-д үйлдвэрлэгдсэн DUSTTRACK-8520 багажаар 20 минутын хугацаатайгаар PM 10, PM 2.5 тоосонцорыг, хүхэрлэг хий /SO₂/, азотын давхар исэл /NO₂/-ийн дээжийг Япон улсад үйлдвэрлэгдсэн агаараас дээж авахад зориулагдсан автомат дампын багажаар 20 минутийн сорьц авч нойтон химийн аргаар мэргэжлийн лабораторид тодорхойлуулсан. Мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн агаарын тоосонцрын pm-2.5, pm-10.0, нийт тоосонцорын хэмжээг дараах хүснэгт харуулав.



Агаарын нийт тоосонцор хэмжих DUST TRAK DRX 8530




Агаар дахь хүхэрлэг хий /SO₂/, азотын давхар исэл /NO₂/-ийг тодорхойлогч багаж

Хүснэгт 22. Агаар дахь тоосны хэмжилт хийсэн цэгүүдийн байршлын мэдээлэл

№	Мониторингийн цэгүүд	Байршил	Байршлын координат		
			UTM 50T		ДТД
1.	AirMoNP-01	Ил уурхай дотор	E5309039.83	N384683.104	745.56 м
2.	AirMoNP-02	Засварын талбай	E5309039.833	N384683.104	745.56 м
3.	AirMoNP-03	Овоолго / Отволь/			
4.	AirMoNP-04	Овоолго	E5309733.587	N385501.787	769.81 м
5.	AirMoNP-05	Тээврийн зам	E5309049.046	N386003.951	749.23 м
6.	AirMoNP-06	Кемп	E5314021.931	N386092.837	706.05м

7.	AirMoNP-07	Дотоод тээврийн зам	E5308668.613	N385999.879	744.32 м
----	------------	---------------------	--------------	-------------	----------


“Хашаатын цав” хүрэн нүүрсний ил уурхайн агаарын чанарын хяналтын цэгүүд



Ил уурхай дотор



Уурхайн шимт хөрс



Гадаад овоолго



Тээврийн дотоод зам



Хөрсний гадаад овоолго



Кемп орчим

Зураг 39. Хашаат цав уурхайн агаарын тоосжилт хэмжих буй байдал

Хүснэгт 23. MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага. Агаар дахь түгээмэл тархацтай бохирдуулах бодисын хүлцэх агууламж болон физикийн сөрөг нөлөөллийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ.

№	Үзүүлэлтийн нэр	Хэмжих дундаж хугацаа	Хэмжих нэгж	Хүлцэх агууламж
1.	Хүхэрлэг хий (SO ₂)	20 минутын дундаж	мкг/м ³	450
		24 цагийн дундаж		50
		Жилийн дундаж		20
2.	Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO)	20 минутын дундаж	мкг/м ³	60000
		24 цагийн дундаж		30000
		Жилийн дундаж		10000
3.	Азотын давхар исэл (NO ₂)	20 минутын дундаж	мкг/м ³	200
		24 цагийн дундаж		50
		Жилийн дундаж		40
4.	Озон (O ₃)	8 цагийн дундаж	мкг/м ³	100
5.	Нийт тоосонцор	20 минутын дундаж	мкг/м ³	500
		24 цагийн дундаж		150
		Жилийн дундаж		100
6.	PM 10 тоосонцор	24 цагийн дундаж	мкг/м ³	100
		Жилийн дундаж		50
7.	PM 2.5 тоосонцор	24 цагийн дундаж	мкг/м ³	50
		Жилийн дундаж		25
8.	Хар тугалга (Pb)	24 цагийн дундаж	мкг/м ³	1
		Жилийн дундаж		0.25
9.	Бензапирен (C ₂₀ H ₁₂)	24 цагийн дундаж	мкг/м ³	0.001

Хүснэгт 24. Зөвлөмж, агаар дахь тоосонцорын стандартаар зөвшөөрөгдөх дээд хэмжээ, мг/м³


	PM 2.5 тоосонцор		PM 10 тоосонцор	
	Жилийн дундаж	24 цагийн дундаж	Жилийн дундаж	24 цагийн дундаж
Монгол улсын АЧС	0.025	0.05	0.05	0.1
ДЭМБ-ийн зөвлөмж, 2005	0.01	0.025	0.02	0.05
ДЭМБ-ийн дундны шатны зорилт				
IT-1	0.035	0.075	0.07	0.015
IT-1	0.025	0.05	0.05	0.1
IT-1	0.015	0.0375	0.03	0.075

Хүснэгт 25. “Хашаатын цав” хүрэн нүүрсний ил уурхайн хяналтын цэгүүдийн үр дүн

Хяналтын цэг	Хяналтын цэгүүдийн нэр	Нийт тоосонцор, мкг/м ³ хяналтын үр дүн					
		03 сар	05 сар	07 сар	08 сар	09сар	10 сар
1 - хяналтын цэг	Ил уурхай дотор	229	84	88.0	84	200	33
2 - хяналтын цэг	Засварын талбай	148	52	42.00	36	349	14
3- хяналтын цэг	Овоолго / Отволь/	839	103	24.0	24	140	14
4- хяналтын цэг	Овоолго	328	-	31.0	24	120	13
5- хяналтын цэг	Кемп	14	4	6.0	10	12	14
6- Хяналтын цэг	ШТС-ын орчим	10	-	17.0	8	10	-
7- Хяналтын цэг	Тээврийн зам	23	139	91.0	15	250	33
Стандарт MNS 4585:2016		500.0	500.0	500.0	500.0	500.0	500.0

Төслийн талбайн нийт тоосны түвшин:

20 минутын хугацаанд хэмжилт хийсэн талбайнуудын нийт тоосонцорын хэмжилтийн утгыг Монгол улсын стандарттай харьцуулж доорх графикт харуулав. Нийт хугацааны хэмжилтийн дундаж утгыг Монгол улсын агаарын чанарын стандарттай харьцуулж харвал бүх хяналтын цэгүүдийн тоосжилт хүлцэх хэмжээнд байсан ба уурхайн карьер бол бусад талбайн тоосжилтийн нийт хугацаанд бусад талбайнаас өндөр агууламжтай байна.





Нийт тоосонцор: Агаар дахь нийт тоосонцорын дундаж агууламж хэмжилтийн цэгүүд дээр 6-391 мкг/м³ хооронд тодорхойлогдсон байна. Уурхайн хяналтын цэгүүдээс агаарын нийт тоосонцорын агууламж 3 болон 9 саруудад уурхайн карьер, хөрсний овоолго болон гадаад овоолго дээр бусад хяналтын цэгүүдээс өндөр байна.

Азотын давхар исэлийн агууламж

20 минутын хугацаанд хэмжилт хийсэн талбайнуудын азотын давхар ислийн агууламж (NO₂) хэмжилтийн утгыг Монгол улсын стандарттай харьцуулж дээрх графикт харуулав. Дээрх үр дүнгээс харахад нийт хугацааны азотын давхар ислийн агууламж дундаж утгыг Монгол улсын агаарын чанарын стандарттай харьцуулж харвал хүлцэх хэмжээнд байна.



Хяналтын цэг	Хяналтын цэгүүдийн нэр	07 сарын хяналтын үр дүн		
		Нийт тоосонцор, мкг/м ³	Азотын давхар исэл, мкг/м ³	Хүхэрлэг хий, мкг/м ³
1 - хяналтын цэг	Ил уурхай дотор	88.0	9.0	11.0
2 - хяналтын цэг	Засварын талбай	42.00	9.0	4.0

3- хяналтын цэг	Овоолго / Отволь/	24.0	7.0	6.0
4- хяналтын цэг	Овоолго	31.0	13.0	5.0
5- хяналтын цэг	Кемп	6.0	18.0	7.0
6- Хяналтын цэг	ШТС-ын орчим	17.0	15.0	9.0
7- Хяналтын цэг	Дотоод тээврийн зам	91.0	11.0	8.0
Стандарт MNS 4585:2016		500.0	200.0	450.0



Хүхэрлэг хийн агууламж

20 минутын хугацаанд хэмжилт хийсэн талбайнуудын хүхэрлэн хийн агууламж (SO₂) хэмжилтийн утгыг Монгол улсын стандарттай харьцуулж дээрх графикт харуулав. Дээрх үр дүнгээс харахад нийт уурхайн хяналтын цэгүүдийн хэмжилт хийсэн хугацааны хүхэрлэг хийн агууламж дундаж утгыг Монгол улсын агаарын чанарын стандарттай харьцуулж харвал хүлцэх хэмжээнд байна.

УУРХАЙН УСНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ

Уурхайн унд ахуйн усны шинжилгээ, хяналт

Хашаатын цав уурхайн ажилчдын ундны усыг кемпийн талбайд гаргасан гүний худгаас хангадаг. Ундны усны гүний худгийн ундарга 2.0 л/сек, худгийн өрөмдлөгийн гүн 60 метр, уст давхарга нь 38 метр байна. Тус худагт унд ахуйн худагт LXSGR-32 маркын 10м³/цаг хэмжих хягзаартай, 32 мм голчтой №201301872 дугартай тоолуурыг 1-р лац №014, 2-р лац дугаар MGL343064 дугаартай битүүмжилсэн 00001 заалттай 2023 оны 05 сарын 10-нд тоолуур тавьсан байсан.



Зураг 40. Ундны усыг хангаж буй гүний худгийн эх үүсвэрт тоолууржуулсан байдал





Зураг 41. Ундны ус хангаж буй усны эх үүсвэрүүдээс шинжилгээнд зориулаж усны дээж авсан байдал

Хүснэгт 26. Хашаатын цав уурхайн ундны усны шинжилгээний үр дүнгүүд

Шинжилгээний үзүүлэлт	Стандарт шаардлага	03 сар	05 сар	07 сар	
Усны дээжний төрлүүд		Унд	Унд	Унд	Усны сав
ББЕТ	-	4	1мл-52	-	-
Халуун тэсвэртэй гэдэсний бүлгийн нян	-	илрээгүй	илрээгүй	-	-
Колиформ бүлгийн гэдэсний нянгийн тоо	-	илрээгүй	илрээгүй	-	-
Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян	-	илрээгүй	илрээгүй	-	-
K ⁺ , мг/л	1.78	1.87		1.78	1.72
Na ⁺ , мг/л	229.0	252.5		229.0	219.1
NH ₄ ⁺ , мг/л	<0.10	<0.10		<0.10	1.50
Ca ²⁺ , мг/л	25.80	19.68	20.04	25.80	24.95
Mg ²⁺ , мг/л	31.56	33.94	66.88	31.56	30.44
НИЙЛБЭР КАТИОН		308.0	-		
Cl ⁺ , мг/л	79.98	119.1	7.09	79.98	83.38
SO ₄ ²⁻ , мг/л	148.3	129.9	14.9	148.3	140.2
NO ₂ ⁻ , мг/л	<0.05	<0.06	0.033	<0.05	<0.05
NO ₃ ²⁻ мг/л	0.08	2.16	1.24	0.08	0.09
CO ₄ ²⁻	<1.50	<0.50	-	<1.50	<1.50
HCO ₃ ⁻	533.0	479.0	-	533.0	530.8
НИЙЛБЭР АНИОН	-	745.0	-	-	-
НИЙЛБЭР ИОН	-	1053	-	-	-
pH	7.41	7.86		7.41	7.58
H ₂ SiO ₃ , мг/л	36.41	25.14		36.41	37.25
Хуурай үлдэгдэл	844.0	848.0	816.0	844.0	838.0
Исэлдүүлэх чадвар	5.44	2.54	-	5.44	5.36
Хатуулаг	3.88	3.78	3.75	3.88	3.75

Усны шинжилгээний химийн үзүүлэлтээр магнийн агууламж харьцсангүй өндөр бусад үзүүлэлтүүд стандартын зөвшөөрөгдөх түвшинд байна. Ундны усны эх үүсвэрийн худгаас кемп хүрэх шат дамжлагатай бүх эх үүсвэрүүдийн усны шинжилгээний үр дүнгээр MNS 0900:2018 Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ стандартын шаардлага хангаж байна.

Уурхайн технологийн усны шинжилгээ, хяналт

Хашаатын цав уурхайн зам талбайн тоосжилтыг уурхайн гүний шүүрлийн усаар хангадаг мөн ногоон байгууламжийн модны усалгааг гүний худгаар хангадаг байна. Технологийн гүний худгийн ундарга 1.8 л/сек, худгийн өрөмдлөгийн гүн 120 метр, уст давхарга нь 97 метр байна. Тус ногоон байгууламжийн усалгааны зориулалтаар ашиглах худагт LXSC-40 маркын 16 м³/цаг хэмжих хязгаартай, 40мм голчтой №ЭУ068871 дугартай тоолуурыг 1-р лац №019, 2-р лац дугаар MGL543031 дугаартай битүүмжилсэн 00001 заалттай) 2023 оны 03 сарын 10-нд тоолуур тавьсан байсан.



Зураг 42. Мод, ногоон байгууламжийн усалгааны гүний худаг



Зураг 43. Мод, ногоон байгууламжийн усалгааны гүний худаг

Хүснэгт 27. Хашаатын цавын уурхайн усны хяналтын цэгүүд

№	Усны эх үүсвэр	Шинжилсэн огноо	Шинжилгээ хийлгэсэн үзүүлэлтүүд	Шинжилсэн газар
1.	Хашаатын цавын уурхайн ундны усны худаг	2023.07.07	Ерөнхий хим,	“Хан-Лав” ХХК-ний итгэмжлэгдсэн усны лаборатори
2.	Хашаатын цавын уурхайн гал тогооны ус	2023.07.07	Ерөнхий хим,	
3.	Хашаатын цавын уурхайн шүүрлийн ус	2023.07.07	Хаягдал усны ерөнхий шаардлага	

Хүснэгт 28. Хашаат цав уурхайн гүний худгуудын усны шинжилгээний үр дүн

№	Шинжилгээ хийсэн элементүүд	Нэгж	MNS 0900:2018	“Ган Алтан Наран” ХХК -ний Гал тогоо	“Ган Алтан Наран” ХХК -ний ундны ус	Шүүрлийн ус /хаягдал ус/
1	рН	-	6.5-8.5	7.41	7.58	7.86
2	Кали (K ⁺)	мг/л	-	1.78	1.72	1.78
3	Натри (Na ⁺)	мг/л	200.0	229.0	219.0	229.0
4	Кальци (Ca ²⁺)	мг/л	100.0	25.80	24.95	25.80
5	Магни (Mg ²⁺)	мг/л	30.0	31,56	30.44	31,56
6	Аммони (NH ₄ ⁺)	мг/л	1.50	<0.10	<0.10	<0.10
7	Хлорид (Cl ⁻)	мг/л	350.0	79.98	83.38	79.98
8	Сульфат(SO ₄ ²⁻)	мг/л	500.00	148.3	140.2	148.3
9	Нитрит (NO ₂ ⁻)	мг/л	1.0	<0.05	<0.05	<0.05
10	Нитрат(NO ₃ ⁻)	мг/л	50.0	0.08	0.09	0.08
11	Корбанат (CO ₃ ²⁻)	мг/л	-	<1.50	<1.50	<1.50
12	Гидрокарбонат (HCO ₃ ²⁻)	мг/л	-	533.9	530.8	533.9
13	Нийт хатуулаг	мг-экв/л	7.0	3.88	3.75	3.88
14	Хуурай үлдэгдэл, TDS	мг/л	1000.0	844.0	838.0	844.0
15	Цахиурын хүчил, (H ₂ SiO ₃)	мг/л	-	36.41	37.25	36.41
16	Исэлдэх чадвар, (KMnO ₄)	мг O ₂ /л	-	5.44	5.36	5.44
17	Фосфат, (PO ₄ ³⁻)	мг/л	3.5	0.48	-	0.48
18	Фтор, F ⁻	мг/л	0.30	4.48	-	4.48
19	Хүхэртүстөрөгч, (H ₂ S)	мг/л	0.7-1.5	<0.10	-	<0.10
20	Чөлөөт хлорид, (Cl _{чөл})	мг/л	0.1	<0.10	-	<0.10
21	Булингар,	NTU	0.2-0.3	<10.0	-	<10.0
22	Мөнгө, Ag	мг/л	1.5	<0.01	-	<0.01
23	Хөнгөн цагаан, Al	мг/л	0.1	<0.025	-	<0.025
24	Мышьяк, As	мг/л	0.50	<0.01	-	<0.01
25	Бор, B	мг/л	0.01	0.92	-	0.92
26	Бари, Ba	мг/л	2.40	<0.01	-	<0.01
27	Берелли, Be	мг/л	0.70	<0.001	-	<0.001
28	Кадми, Cd	мг/л	0.0002	<0.005	-	<0.005
29	Кобальт, Co	мг/л	-	0.001	-	0.001
30	Хром, Cr	мг/л	0.05	<0.005	-	<0.005
31	Зэс, Cu	мг/л	2.0	<0.02	-	<0.02
32	Төмөр, Fe	мг/л	0.3	<0.03	-	<0.03
33	Марганец, Mn	мг/л	0.1	0.03	-	0.03
34	Молибден, Mo	мг/л	0.07	0.01	-	0.01
35	Никель, Ni	мг/л	0.02	<0.005	-	<0.005
36	Хартугалга, Pb	мг/л	0.01	<0.01	-	<0.01
37	Сурьма, Sb	мг/л	0.02	<0.01	-	<0.01
38	Селен, Se	мг/л	0.04	<0.05	-	<0.05

39	Стронци, Sr	мг/л	2.00	0.81	-	0.81
40	Уран, U	мг/л	0.03	<0.10	-	<0.10
41	Цайр, Zn	мг/л	5.0	0.09	-	0.09
42	Цианид, CN _{free}	мг/л	0.01	<0.002	-	<0.002
43	Мөнгөн ус, Hg	мг/л	0.001	<0.001	-	<0.001

Усны шинжилгээний химийн үзүүлэлтээр магни, ерөнхий хатуулаг агууламж харьцсангуй өндөр бусад үзүүлэлтүүд стандартын зөвшөөрөгдөх түвшинд байна. Ундны усны эх үүсвэрийн худгаас кемп хүрэх шат дамжлагатай бүх эх үүсвэрүүдийн усны шинжилгээний үр дүнгээр MNS 0900:2018 Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ стандартын шаардлага хангаж байна.

Хүснэгт 29. Хашаат цав уурхайн уурхайгаас гарсан шүүрлийн усны шинжилгээний үр дүн

№	Шинжилгээ хийсэн элементүүд	Нэгж	дүн		
			MNS 0900:2018	Шүүрлийн ус /хаягдал ус/	Шүүрлийн ус /хаягдал ус/
1	pH	-	6.0-9.0	7.86	7.86
2	Чөлөөт хлорид, (Cl _{чөл})	мг/л	1.0	>0.10	>0.10
3	Хуурай үлдэгдэл, TDS	мг/л	1000.0	368.0	368.0
4	Умбуур бодис, TSS	мг/л	30.0	632.0	632.0
5	Исэлдэх чадвар, (KMnO ₄)	мг O ₂ /л	20.0	46.40	46.40
6	Химийн хэрэгцээт хүчилтөрөгч, COD	мг/л	50.0	122.0	122.0
7	Биологийн хэрэгцээт хүчилтөрөгч, BOD	мг/л	20.0	42.32	42.32
8	Хүхэртустөрөгч, (H ₂ S)	мг/л	0.5	<0.10	<0.10
9	Хром, Cr (VI)	мг/л	0.01	<0.05	<0.05
10	Хөнгөн цагаан, Al	мг/л	0.5	0.40	0.40
11	Мышьяк, As	мг/л	0.01	<0.01	<0.01
12	Бор, B	мг/л	0.50	<0.001	<0.001
13	Бари, Ba	мг-экв/л	1.5	0.002	0.002
14	Берелли, Be	мг/л	0.001	<0.005	<0.005
15	Кадми, Cd	мг/л	0.02	<0.005	<0.005
16	Кобальт, Co	мг/л	0.03	0.16	0.16
17	Хром, Cr	мг/л	0.3	0.01	0.01
18	Зэс, Cu	мг/л	1.0	<0.005	<0.005
19	Төмөр, Fe	мг/л	1.0	<0.005	<0.005
20	Марганец, Mn	мг/л	0.5	0.10	0.10
21	Молибден, Mo	NTU	0.5	<0.01	<0.01
22	Никель, Ni	мг/л	0.2	<0.01	<0.01
23	Фосфор, P	мг/л	1.5	<0.01	<0.01
24	Хартугалга, Pb	мг/л	0.1	0.20	0.20
25	Сурьма, Sb	мг/л	0.05	0.02	0.02
26	Селен, Se	мг/л	0.02	<0.10	<0.10
27	Стронци, Sr	мг/л	2.0	0.20	0.20
28	Ванади, V	мг/л	0.10	0.02	0.02
29	Уран, U	мг/л	0.05	<0.10	<0.10
30	Цайр, Zn	мг/л	3.0	<0.01	<0.01
31	Цианид, CN _{free}	мг/л	0.050	<0.002	<0.002
32	Цианид, CN _{tot}	мг/л	0.050	<0.002	<0.002
33	Мөнгөн ус, Hg	мг/л	0.005	<0.001	<0.001

11.3 ХӨРСНИЙ БОХИРДЛЫН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ

Уурхайн үйл ажиллагааны явцад хөрсний бохирдол үүсч болзошгүй байгаль орчны сөрөг нөлөөллүүдийн нэг болно. Уурхайн хөрсний хяналт шинжилгээний тогтсон цэгүүдэд хөрсний хүнд металлын шинжилгээг жилд тогтсон хугацаанд хийлгэж байна. Хашаатын цав уурхайн 8 цэгт хөрсний үндсэн агрохимийн шинж чанар болон хүнд металлын бохирдол байгаа эсэхэд хяналт шинжилгээ хийлгэх ажлыг Улаанбаатар хотын хөрсний шинжилгээний “Ханлаб” болон “Инженер геодези” ХХК хөрсний мэргэжлийн лабораторид шинжилгээ хийлгэсэн болно.

Зураг 44. Уурхайн талбайнуудаас хөрсний дээж авч буй байдал



Хүснэгт 30. Уурхайн хөрсний хяналтын цэгүүдийн хүнд металлын шинжилгээ

Хүнд металл	Шимт хөрс	Гадаад овоолго	Уурхайн тээврийн зам	Засварын талбай	Уурхайн карьер	Кемп	ШТС	MNS5850 :2019
Al	6.97	5.97	5.51	5.46	6.16	7.06	6.39	-
Ca	1.09	0.17	0.51	0.13	0.13	0.82	0.75	-
Mg	0.33	0.25	0.19	0.18	0.24	0.66	0.25	-
K	2.41	2.62	2.48	2.43	2.45	2.99	2.45	-
Fe	1.31	0.77	0.92	0.69	1.2	0.57	1.22	-
As	5	5.48	5	5.42	5	5	5	20.00
Ba	615	681.5	635.3	621.3	625.1	651.7	630.9	-
Be	<5	<5	<5	<5	<5	<5	<5	-
Bi	<10	<10	<10	<10	<10	<10	<10	-
Cd	1	1	1	1	1	1	1	3.00
Co	8.02	6.95	6.12	5	6.95	5	6.65	50.00
Cr	22.18	10.51	12.62	7.29	19.12	10.22	19.58	150.0
Cu	7.71	5	5.04	5	5.54	5	6.5	100.0
La	23.67	32.47	16.2	32.61	18.57	14.53	15.83	-
Li	16.23	9.37	12.03	8.18	13.72	16.96	14.61	-
Mn	267.2	61.74	195.9	33.67	320.3	49.71	292.4	-
Mo	5	5	5	5	5	5	5	5.0
Ni	8.38	13.09	5.88	11.27	5.61	5.95	6.74	150.0
P	233.2	80.52	140.2	77.24	207.2	66.06	227.2	-
Pb	16.68	14.63	14.32	13.08	13.24	16.35	14.92	100.0
Sb	<10	<10	<10	<10	<10	<10	<10	-
Se	<5	<5	<5	<5	<5	<5	<5	10.0
Sr	232.8	135.8	195.6	113.2	234.9	91.15	226.2	800.0
Ti	1939	1232	1571	846.2	1956	944.6	1865	-
V	38.07	31.99	26.42	28.01	33.57	25.03	34.13	150.0
Y	13.64	18.87	10.16	23.81	12.12	5.72	11.7	-
Zn	70.27	46.22	55.38	44.65	38.67	27.44	38.44	300.0
Zr	63.13	63.78	49.53	44.86	43.96	52.29	47.92	-

УУРХАЙН ШИМТ ХӨРСНИЙ ШИНЖ ЧАНАР

Шимт хөрсийг уурхайн хүрэнээс 1.6 км-ийн зайд баруун хойд хэсэгт шимт хөрсний овоолго руу тээвэрлэнэ. Шимт хөрсний овоолгын 4.7-7.4 метрийн өндөртэй 250-300 градусын налуутайгаар үерийн ус болон салхины нөлөө бага байх газар байгуулсан. Шимт хөрсийг уурхай, овоолгын суурийн талбайгаас 0.2 метрийн зузаантай хуулагдсан. Нийт 2022 онд 972, 042м³, 2023 оны 11 сарын байдлаар 22,722 м³ шимт 29,0 га талбайд шимт хөрсний овоолго байгуулан хадгалж байгаа болно. 2022 онд нийт 1.7 га хөрсний талбайг ургамалжуулсан бол 2023 онд нийт 1.0 га орчим шимт хөрсний талбайд хөрсний элэгдлээс хамгаалах зорилгоор олон настын ургамал тарьж ургамалжуулсан байна.



Зураг 45. Уурхайн шимт хөрсний овоолго

Хүснэгт 31. Шимт хөрсний үржил шимийн агрохимийн шинжилгээний үр дүн

№	Дээжний нэр	РН	Давс,%	ЦДЧ, dsm	Ялзмаг, %	CaCO ₂ , %	Шингээгдсэн сууриуд мг-экв/100гр		Шимт тэжээлийн элементүүд мг/100гр	
							Ca	Mg	P ₂ O ₂	K ₂ O
1	Шимт хөрс-2022	8.28	0.02	0.040	1.88	0.00	14.0	6.9	1.6	4.0
2	Шимт хөрс-2022	8.28	0.02	0.040	1.88	0.00	14.0	6.9	1.6	4.0
Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ, мм										
№	Дээжний нэр	Г _{үн} , см	1.0-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01	
1	Шимт хөрс	-	32.1	48.4	5.2	2.8	5.5	5.9	14.3	

ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ҮР ДҮН

Дорнод аймгийн Баянтүмэн сумын нутагт орших МУ-020936 тоот тусгай зөвшөөрөл бүхий “Хашаатын цав” хүрэн нүүрсний ордын 2023 оны байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг 2023 оны 07-р сарын 20-23-ны өдрүүдэд Улаанбаатар хотоос Байгаль орчны мэргэжлийн байгууллага хийж гүйцэтгэсэн.

07 дүгээр сарын хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд агаарын чанарын хяналт шинжилгээ, гүний усны хяналт-шинжилгээгээр ундны ахуйн усны чанар хяналт, хөрсний хяналт шинжилгээний ажлууд болон уурхайн хүрээнд хийгдсэн.

Уурхайн усны шинжилгээгээр ажилчдын унд ахуйн ус, технологийн уснаас дээж авч шинжилгээ хийгдсэн ба шинжилгээний үр дүнгүүд МУ-д мөрдөгдөж буй ундны стандартын хэмжээнд байна. “Ган Алтан Наран” ХХК -ний ундны худаг магни агууламж стандартаас өндөр гарсан байна. Унд ахуйн усны бусад үзүүлэлт ундны усны чанарын стандартаас давсан тохиолдол ажиглагдаагүй байна.

Тус уурхайн нийт 8-н ширхэг хөрсний дээжид ямар нэгэн хүнд металл стандарт давсан төвшингөөс хэтэрсэн үзүүлэлт байхгүй хэвийн мөн хуулсан шимт хөрсний шимт чанар ялзмагийн агууламж 1.66-1.88 хувьтай байна. Уурхайн шатахуун түгээх станц, засварын газар, талбайнуудын хөрсний хүнд металлын агууламж стандартын хүлцэх агууламжаас давсан үзүүлэлт илрээгүй байна.

Уурхайн 8 хяналтын цэгүүдийн агаарын тоосжилтын хэмжилтийн үр дүнгээр өмнөх саруудын үр дүнтэй харьцуулахад хэвийн “Агаарын чанарын стандарт /MNS4585:2016/”-ын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага үзүүлэлттэй гарсан байгаа нь зам талбайн тоосжилтыг бууруулах усалгааны ажлыг тогтмол хийдэг болохыг харуулж байгаа юм. Нийт тоосонцрын агууламж уурхайн карьер, тээврийн зам зэрэгт харьцангуй бусад хяналтын цэгүүдээс өндөр агууламжтай байгаа нь байнгын хөдөлгөөн, олборлолтын үйл ажиллагаа тогтмол явагдаж байгаатай холбоотой байна гэсэн дүгнэлыгэд хүрсэн.

ДҮГНЭЛТ

Дорнод аймгийн Баянтүмэн сумын нутагт MV-020936 тус тусгай зөвшөөрөл бүхий хүрэн нүүрсний ил уурхайн ашиглалт, олборлолтыг 2021 оны 12 сараас эхлэн уурхайн олборлолт, хөрс хуулалтын ажил явагдаж байна. 2023 онд уурхайн туслан гүйцэтгэгч “Зак Майнинг” ХХК, кемп кетрингийн үйлчилгээний “Ган Алтан Наран” ХХК нийт туслан нэг компаниуд тухайн уулын ажил, хөрс хуулалтын ажлыг гүйцэтгэсэн байна. “Хашаатын цав” хүрэн нүүрсний ил уурхайн олборлолтын талбай 159.06 га талбайн тэлэлт хийгдээгүй 2023 онд уурхайн хөрс хуулалт төслийн 11 сарын байдлаар нийт уулын цул 5,023,463 м³, хөрс 4,642,637 м³, 20,772 м³ шимт хөрс, 360,054 м³ нүүрс олборлосон байна.

2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөсөн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажилласан.

Төслөөс газрын гадарга, газрын хэвлийд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл нь уул уурхайн үйл ажиллагаанаас үүсэлтэй газрын эвдрэл, мөн техник хэрэгсэл, тээврийн нөлөөгөөр газрын бүрхэвч элэгдэх газрын эвдрэл нөлөөллүүд болж байна. Хашаатын цав уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр 2023 оны 11 сарын байдлаар ерөнхий уурхайн карьер олборлолтын үйл ажиллагаанд 80.0 га, нийт уурхайн үйл ажиллагаанд өртсөн газар 310.0 га орсон байна.

Уурхайг ил аргаар ашиглах явцад байгаль орчны гол сөрөг нөлөөлөл болох уурхайн тоосжилт их бага хэмжээгээр үүсч байгаа тул уурхайн усалгааны ажлыг 3 сарын 1-н нэгээс эхлүүлэн 11 сарын 1 хүртэл тасралтгүй хийж байна. Уурхайн дотоод замуудаас үүсэх тоосжилтыг бууруулах, багасгах зорилгоор шороон замуудыг сайжруулах, давхар хөрсний дэвсэлт 30-40 см зузаан хийснээр замын хөдөлгөөнөөс үүсэх тоосжилт харьцангуй буурч байна. Зам талбайн тоосжилт бууруулах зорилгоор нийт шүүрлийн болон гүний худгаас 23030 м³, 7-8 саруудад худгийн уснаас гадна хур бороо ихтэй байсан, зам талбайн усалгааны зориулалтаар ашиглаж усны нөөц ашигласны төлбөр 15,000,000 орчим төгрөг татварын албанд төвлөрүүлсэн.

Хашаатын цавын уурхайн усан хангамжийн үндсэн эх үүсвэр нь гүний худаг буюу уурхайн шүүрлийн ус юм. Усны тухай хуулийн 28.2-т заасанчлан 2022 оны ус ашигуулах дүгнэлтийг “Усны Газар” ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлагаас тухайн жилийн ус ашиглах төлөвлөгөөнд дээр үндэслэн ус ашиглах хэмжээг зориулалт тус бүрээр тооцоолон ус ашиглах дүгнэлтийн дагуу ашиглалт явуулж, усны эх үүсвэр бүрийг тоолууржуулсан байна.

2023 оны Хашаатын цав уурхайн, хөрс хамгаалах ажлаар уурхайн хуулсан шимт хөрсийг ургамалжуулах, хамгаалах ажлын дагуу олон настын үр тарилт хийх ажлыг 6 сард зохион байгуулсан. Шимт хөрсний 0.5га талбайд хөрс бэлтгэх, олон настын ургамал болох хошоон, хүцэнгэ, согоовор, өлөнгө нөмрөг зэрэг ургамалжуулах ажлыг гар аргаар гүйцэтгэсэн. Тухайн ургамалжуулсан ажлын үр дүн маш сайн тухан ургамлууд ургасан.

Уурхайн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу туслан гүйцэтгэгч компани сар бүр 6-8 цэгт сар бүр тоосжилт, улиралд нэг хөрсний шинжилгээ, сар бүр усны шинжилгээний хяналтыг гүйцэтгүүлсэн. Ус, хөрсний шинжилгээний үр дүнгүүд тухайн холбогдох стандартын хэмжээнд байна. Уурхайн тоосжилтын хяналтын цэгүүдээс хамгийн өндөр тоосжилттой байгаа нь уурхайн карьер, тээврийн замууд болон хөрсний овоолгууд байна.

Хог хаягдлын менежментийн хүрээнд уурхайн гүйцэтгэгч компани бүр хог хаягдлын тусгай цэгт ахуйн хаяг хаягдлыг түр хугацаагаар хадгалж гэрээний дагуу Баянтүмэн сумын нэгдсэн хогийн цэгт хүргүүлэн нийлүүлэн ажиллаж байна. Хог хаягдлын менежментийн сайржуулах, хог хаягдлыг ангилан ялгаж хэвших, дахин боловсруулах хаягдлуудыг ангилан ялгаж энэ чиглэлээр уурхайн ажилчдад тогтмол сургалт, сурталчилгааны ажлууд хийгдэж байна. Хог хаягдлын төлбөрийг Баянтүмэн сумын татварт төвлөрүүлэн ажиллаж байна.

Уурхайн кемпийн гал тогоо, душ, ариун цэврийн байгууламжийг шинээр барьж ахуйн бохир шингэн хаягдлыг цэвэрлэх бага оврын “Эколос Алтай” ХХК-ний ОХУ-д үйлдвэрлэгдсэн Экогранд-100 маркийн бага оврын хоногт 60-100м³ ахуй бохир ус цэвэршүүлэх /300 хүний/ хүчин чадалтай бага оврын цэвэрлэх байгууламжийг 2023.10.12-нд суурилуулсан. Уг цэвэрлэх байгууламж нь бохир усыг 85-90 хувь хүртэл цэвэршүүлж, цэвэршүүлсэн стандартын шаардлага хангасан байгальд нийлүүлэх боломжтой хаягдал усыг хөрсөнд шингээх юм байна.

Өмнөх жилийн Хутагт ууланд нутагшуулсан 25 тоо толгой бүхий Монгол тарвага нутагшуулсан тухайн ажлын үр дүнд энэ жил хяналт мониторинг судалгаагаар эхний үр дүнгийн ажиглалтаар 28 тоо толгой үүнээс 6 нь мөндөл ,2 дахь ажиглалтаар 36 тоо толгой бүхий тарвага тохиолдсоноос 13-н нь мөндөл ажиглагдсан. Ажиглалт мониторингийн судалгааны үр дүнгээс үзэхэд тус хамгаалалттай газарт Монгол тарвага идээшин дасан зохицож нутагшиж амьдрах боломжтой бидний судалгаа харуулж байна.

Уурхайн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор шинээр илэрвэл тус компани дотоод журамтай. Хашаатын цав уурхайн 2023 онд хөрс хуулалтын явцад чулуужсан мод энэ жил илэрээгүй болно.

БОАЖЯамаас зохион байгуулан хэрэгжүүлж буй “НӨХӨН СЭРГЭЭЛТ-2024” улсын хэмжээнд эвдэрсэн газрын бүртгэлийн эвдэрч орхигдсон талбайнуудад техникийн нөхөн сэргээлт гүйцэтгэх ажлын хүрээнд 2023 оны нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгагдсан Дорнод аймгийн Хэрлэн сумын 2р багийн нутагт хуучин эвдэрч орхигдсон карьерын 2.0 га талбайд техникийн нөхөн сэргээлт ажлыг гүйцэтгэсэн. Нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн гүйцэтгэхэд техникийн түлш, түрээс, ажилчдын ажлын хөлс г.м тухайн ажилд 27.0 сая төгрөгийн зардал төсөв гарган ажилласан байна.

Байгаль орчны хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх ажилд 130.6 сая төгрөг зарцуулсан байна.

Ус байгалийн нөөц ашигласны төлбөрт 15,000,00.0 төгрөг, хог хаягдал нийлүүлсэн төлбөр 20,000,000 төгрөг орон нутгийн төсөвт төлөхөөр болж байна.

Байгаль орчны нөхөн сэргээлтийн барьцаа төлбөрд тухайн жилд 34,142,000 төгрөгийг БОАЖЯамны нөхөн сэргээлтийн тусгай дансанд байршуулсан.

ХАВСРАЛТ МАТЕРИАЛ

1. Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар
2. Тусгай зөвшөөрлийн хуулбар

НӨХӨН СЭРГЭЭЛТ, ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАЛТ

3. БОХ-3 уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрын мэдээлэл
4. Нөхөн сэргээлтийн акт хуулбар хувь
5. Нөхөн сэргээлт гүйцэтгэсэн ажлын тайлан нүүр хуулбар

УС АШИГЛАЛТ

6. 2023 оны ус ашиглуулах дүгнэлт хуулбар хувь
7. Ус ашиглах зөвшөөрөл, гэрээний хуулбар хувь
8. Сар бүрийн тоолуур баталгаажуулсан актуудын хуулбар хувь
9. Ус ашигслсны төлбөр төлсөн баримтууд хуулбар хувь
10. Усны шинжилгээний үр дүнгүүдийн хуулбар хувь
11. Бохир ус соруулах гэрээний хуулбар хувь

ХОГ ХАЯГДАЛ

12. Хог хаягдал нийлүүлэх гэрээний хуулбар хувь
13. Гүйцэтгэгч компаниудын аюултай хаягдал шилжүүлэх, нийлүүлэх гэрээ хуулбар хувь
14. Аюултай хаягдлын хэмжээ
15. Хог ачуулсан бүртгэл хуулбар хувь

ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

16. Агаарын шинжилгээний үр дүнгүүд хуулбар хувь
17. Хөрсний шинжилгээний үр дүнгүүд хуулбар хувь